



С. НАДМИД

НАЙМУУЛАА



Самбуугийн НАДМНА



Улаанбаатар хот  
2007 он

С.Надмид  
НАЙМУУЛАА

Сургуулийн бага, дунд насныханд зориулав.

Зураач Ж.Хаш-Эрдэнэ  
Хянан тохиолдуулагч О.Мөнхтуяа  
Дизайнер Т.Дэлгэрмаа



Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК

2007 он



## ЭХЛЭЛ

Даагаа наймуулаа байсан юм. Түүнд хүүхдүүд хайртай байлаа. Хөөрхий тэр нохойг муу нөхөр хорлоогүй бол улам ч олуулаа, улам ч олон хүний хайрыг татах байсан биз. Гэвч Даагааг дурсах хүүхэд бишгүй бий. Яагаад гэвэл жаахан ч гэсэн гавъяа байгуулсан намтар түүхтэй. Хүний амьдралд тэр хайртай байсан юм.

## ГАНЦААРАА

Өдрийн ихэнхийг гэрт ганцаараа өнгөрөөх нь Жаалхүүд уйтгартай. Аав ээж хоёр нь өглөө эрт ажилдаа явна. Тэдний дараахан ах, эгч нар нь цүнхээ аваад гэрээс гарна.

-Миний дүү босоорой, хаалгаа түгжээрэй! гэж хэлээд Дашиймаа эгчийгээ гадагш гармагц хүү хөнжлөө өшиглөн өндийж, бараг л нүдээ аньсан чигээр гүйж очоод үүдээ дотроос нь түгжив. Тэгээд орондоо орж жаахан хэвтэв. Унтмаар санагдавч нойр нь хүрэхгүй. Албаар унтах гэж нүдээ аниад ч нэмэргүй.

Нэгэнтээ нойр хулжсан болохоор нүцгэн туранхай шуугаа ил гарган, эгээ л том хүн шиг гараа салаавчлан дэрлээд, чанх дээшээ харж хэвтэв. Хүү эмээгээ байсан бол яавч ингэж хэвтэхгүй. Эмээ нь түүнийг ингэж хэвтүүлэхгүй.

-Хүүхэд сэрүүтээ босч байх хэрэгтэй. Хэвтмэгцээ унтаж байх ёстой.

Энэ бол эмээгийнх нь сурган захиж байсан үг, нэг ёсны сургууль нь юм.

Тэр өглөө жаалхүүд урьд урьдаас улам ч уйтгартай юм шиг санагдаж байлаа. Гэрт чив чимээгүй. Галын өрөөний цоргоноос үргэлж шахам дусалдаг усны чимээ ч алга. Бодвол Дашиймаа эгч нь усны цоргыг гүйцэд хаагаад явснаас зайлахгүй. Дээд давхрын айлын хүүхдүүд баахан пижигнэж байснаа ажил сургуульдаа явцгаав бололтой ажигнэж байснаа ажигчид сургуульд явцгаав бололтой ажигчид түжин болов. Хажуугийн айлын Болдбаатар хөнжлөөсөө сугарах болоогүй. Түүний сэрэх, босох андашгүй. Эвхдэг ороо шалан дээгүүр түжигнэтэл чирэх буюу хэдэн мухар сандлаа түрэн давхих нь харагдах шиг болно. Болдбаатар бол бас л гэртээ ганцаархнаа үлддэг хүү юм. Тэр Жаалхүүтэй нэг байранд ердөө нимгэхэн ханаар тусгаарлагдан суудаг, бас нэг ангид сурдаг боловч үерхэх нь үгүй. Юунаас болдгийг хүү хэрхэн мэдэх билээ.

Жаалхүү чимээ чагнан хэвтсээр байв. Одоо түүнд зугаатайхан бодлоос нь өөр хань алга. Хүү хэдийгээр нас бие багахан боловч хүмүүст бодол нь хань болдгийг анзаарч мэджээ. Тэр ч байтугай хүн уйтгарлахдаа элдэв зүйлийг боддог, бодоод зогсохгүй өөртэйгөө юмуу, амьгүй юмтай ч ярьж болдгийг мэджээ. Харин нэг зүйлийг төсөөлж огт чадахгүй байв. Юу гэвэл Жаалхүү цэцэрлэгт байхдаа ямархан хөгжилтэй, гоё сайхан байснаа одоо сургуулийн сурагч болсон энэ үетэйгээ зүйрлэн бодоод гэнэт "дордсон" юм шиг санагджээ. Үнэндээ тийм биш юм. Хүн уйтгарлаж байгаагаа мэднэ гэдэг "дордож" байгаагийнх бус, харин ч сүрхий өсч байгаагийн тэмдэг шүү дээ. Жишээ нь Жаалхүү хоёр жилийн өмнө цэцэрлэгт байхдаа уйдаж уйтгарлахаа мэддэггүй байсан даа.

Энэ өдрийн хувьд хүүгийн бодол яриа нэг муу ялаанаас эхэллээ. Ялаа цонхны тэндээс нисч, таазны голоос унжих чийдэнгийн шилний бөөрөн дээр сууснаа, орны аравч дамжин улмаар Жаалхүүгийн хамар уруу дайрах гэв.

"Над уруу яваад хэрэггүй. Цаана чинь галын өрөөнд ахын асгасан элсэн чихэр, үйрүүлж унагасан талхны үртэс зөндөө байгаа. Тийшээ очсон чинь дээр".

Ялаа хүүгийн үгэнд орж байгаа юм шиг нисээд явчихлаа. Яг л ирсэн замаараа орны аравч, чийдэнгийн бөөр, тэндээс цонх, цонхноосоо цааш галын өрөө үрүү нисч одов.

Жаалхүү бодов. “Өнгөрсөн зуны ялаанаас манайд гурван ялаа үлдсэн. Чи лав нэг нь мөн. Чи манайд өвөлжиж байна. Бас хаваржаад зуныг үзнэ гэж бодож байгаа байх. Хэрэв тэгж бодоод байгаа бол ахаас л айж явах хэрэгтэй. Ах чамд өшөөтэй шүү. Ганцхан ороолгоход л чи дуусна даа. Сонин хуйлж байгаад шавхуурдах юм уу, үгүй бол шаахайныхаа улаар пад хийлгээд орхино. Өнгөрсөн зун зуслангийнхаа байшинд хэчнээн олон ялаа устгасан гэж бодно. Мянга хүрсэн байх. Чамд би яаж туслах билээ. Цонхны дулаалганы хөвөн дотор ороод нуугдчихаж чадах уу? Чадлаа ч цэхийтлээ хөлдөнө биз, тийм үү?”.

Энэ сацуу нөгөө ялаа “Чи хэлэв үү” гэсэн шиг дахиад хүрээд ирэв. Бас л тэр хамар уруу нь дайрах гэлээ. Яагаад ч юм хүүгийн дургүй гэнэт хүрчээ. Ерөөсөө муу ялаа мэттэй элдвийг ярьж, түүнийг хэрхэн дулаан өвөлжүүлэх тухай бодох хэрэггүй мэт санагдана.

“Би жоомонд дургүй. Жоом харанхуй ангалаас зүүн нүдээ аниад, баруун нүдээ ирмэсээр гарч ирдэг юм. Тэгээд хүн байхгүй бол талхан дээр шээчхээд сэмхэн зайлдаг. Жоом, хүн үзэгдвэл баруун мөрөн дээгүүрээ эргэж хараад ухаангүй зугтаадаг юм. Жоом надад ингэж л санагддаг. Ялаа чи жоомтой ер нь адилхан амьтан. Аав ёстой заваан залхаг шавж гэсэн. Тэгээд л ах үзсэн газраа нядалдаг байх. Дахиад чи миний хамрыг сонирхов оо! Ахын гараас гарахгүйгээ сайхан мэдээрэй!”

Ялаа айсан байртай алга болов. Хүү ч хөнжлөөсөө сугаран босч, орны өмнө тавьсан богино өмд, улавч хоёроо өмсөөд ажилдаа орлоо. Айлын Болдбаатар ч боссон бололтой ороо түжигнүүлэн чирэх сонсдоно. Эвхдэг орон дээр унтдаг гэж дуулсан болохоор л өглөө бүхэн сонсогддог энэ дуугаар “ороо чирч байна” гэж Жаалхүү тааварладаг ажээ. Тэгэхээс биш харсан удаагүй. Гэртээ юу хийдгийг нь мэдэхгүй. Харин Жаалхүү өөрөө маш их ажил амжуулна.



Эхлээд аавынхаа аягыг “Халуун усанд оруулдаг” юм. Ээж нь аягаа заавал угааж, шүүгээний нүдэнд хийгээд явдаг байтал аав нь шавхруутай чигээр ширээн дээр орхиод одно. Дараа нь эгчийн орыг хураана. Эднийхээс Жаалхүүгээр ороо засуулдаг, хураалгадаг хүн бол зөвхөн эгч нь юм. Тийм залхуу хүн үү гэвэл арай ч үгүй шиг. Дээд сургуулийн оюутан болохоор завгүй байдаг байх гэж хүү бодно. Үнэндээ бүгдийн сүүлд унтдаг хүн бол Дашиймаа.

Том том номыг хэд хэдээр нь зэрэгцүүлж тавиад л уншаад байна. Хоёрхон нүдтэй атал дөрөв, таван номыг зэрэг уншаад байх шиг санагддагийг яана. “Оюутан болох яасан хэцүү юм бэ? Би дээд сургуульд орохгүй” гэж бодсон удаа ч буй. Эгчийгээ дуурайх, түүнтэй адилхан хүн болох, хүүд хэцүү санагджээ. Гэтэл бас Тоомой ахыг дуурайгаад нэмэргүй.

-Унш миний хүү, номоо унш, хичээлээ давт гэж ээжийгээ хэчнээн үглэсэн ч тоохгүй. Эрт унтахыг нь яана. Хоол болох, телевизийн кино эхлэхийн өмнө ороо засаад, дэрээ тавиад бэлдчихсэн байна. Гадагшаа гараад алга болов уу гэтэл хэзээний хөнжилдөө ороод шургачихсан байдаг юм.

“Эгч ах хоёр хоорондоо яасан адилгүй вэ? Эгч номонд дуртай, ах нойронд дуртай. Хүн ер нь дээд сургуульд орохоороо номонд дуртай болдог юм болов уу, номонд дуртай хүн дээд сургуульд ордог юм болов уу?” гэж Жаалхүү нэг удаа боджээ. Бас хожим нь “Эгч аавыг, ах ээжийг дуурайсан гэж хүмүүс ярьдаг. Энэ бол худал. Яагаад гэвэл ээж ахыг бодвол хамаагүй цэвэрч, бас ном уншдаг.

Аав хэдийгээр аягаа угааж үзээгүй боловч эгч шиг ороо хүнээр хураалгадаггүй. Эгч аавтай адилхан алаг нүдтэй боловч шал өөр. Ингэхэд би хэнийг дуурайгаа бол. Би ер нь эмээгээ юмуу, эсвэл бүгдийг нь дуурайсан хүүхэд байх. Нэг хүнийг дуурайснаас олон хүнийг дуурайвал сайн байж болно” гэхчлэн боджээ.

Жаалхүү өөрийнхөө орыг хураагаад хогоо шүүрдэв. Дараа

нь гар нүүрээ угаагаад цайгаа уув. Цайлж суухдаа хүү ганцхан зүйлийг бодно. Эмээгээ л бодно. Эмээ нь ноднингийн өдийд энх тунх байжээ. Тэр ач хүүдээ жигтэйхэн хайртай хүн байв. Өглөө эрт босгоно. Гэрийн ажил хийлгэсний дараа гарыг нь ув улаан болтол хэд дахин угаалгана. Энэ ч ач хүүгээ хайрласных шүү дээ. За тэгээд гар нүүрээ угааж байхад нь талх зүсч, шар тос, элсэн чихэр түрхээд бяцхан дийзэн дээр өрчихсөн байна. Цайны нь халуун хүйтнийг хүртэл тохируулж өгдөг байлаа.

Тэр өдөр хүү талхаа өөрөө зүсч байхдаа аанай л эмээгээ бодож байжээ. "Хөөрхий дөө, эмээ минь эсэн мэнд байсан бол..." гэж бодов. Одоо Жаалхүүд хичээлээ давтах, сүүнд явах хоёр ажил үлдэв. Аль аль нь зугаатай. Сүүнд явах бол бүр ч гоё. Энэ ч аргагүй, сайхан санагддаг байж болох юм. Байшиндаа байхад цонхоор ганцхан зүгийн өчүүхэн юмс харагдана. Дөрвөн том сууцны байшингийн булан, нэг богинохон гудамж, түүгээр зорчих янз бүрийн машин, хүмүүс төдийхөн харагдана. Гадаа гарахаар байшингийн нөгөө талын зүйл бүгд ил. Дэлгүүр үрүү явахаар эргэн тойрны бүх юм тов тодорхой. Ер гадаа гудамжинд гармагц л жигүүр ургасан юм шиг, хаашаа ч хамаагүй нисч болмоор санагддаг болой. Тэр яагаад ч юм, өөртөө шувууных шиг жижигхэн жигүүр байгаа мэт дүрслэн боддог байв. Магадгүй, ганц энэ хүүд бус, бүх хүүхдэд тийм нэг жигүүр байдаг, тэр нь томчуулд харагддаггүй байж болох юм даа.

## ХОЁУЛАА

Жаалхүү Должид эмээгийн дүрлэлд түлхүүрээ тавиад, сүүний мухлаг уруу гүйж явлаа. Муухай хүйтэн саарал өдөр. Дүн өвлийн жавар тачигнаж байгаа болохоор аргагүй. Элс шиг хатуу ширхэгтэй цас хаялж байжээ.



Тохь тух алдагдуулсан тавгүй байдал зөвхөн салхинаас л болж байх шиг хүүд санагдана. Гайтай салхинаас болоод хүмүүс гудамжинд гарч чадахгүй байх мэт. Машиныуд хүртэл салхинд хийсэх адил жигтэй хурдан чавхдаж явна. Үүлс ч ялгаагүй, бие биенийхээ нөмөрт орох гэж тэмүүлэх адил үймэн нүүнэ.

Жаалхүү засмал зам өнгөрөөд гүйж явлаа. Тэгтэл нэг сонин юм харагдав. Эхлээд юу гээч амьтан болохыг таньсангүй. Томоос том улиасны нөмөрт хачин бээвийсэн юм салхи уруу хараад сууж байв. Муур уу гэтэл арай ч биш. Өмнө нь зогсоод тонгойж сайтар ажигласны эцэст “нохойн хүү” гэж мэдлээ.

Жаалхүүг сургуульд орох жил аав нь “Үнэгний хүүхдийг гавар, чононы хүүхдийг бэлтрэг, оготны хүүхдийг гөлчгий, тарваганы хүүхдийг мөндөл, зээрийн хүүхдийг янзага, тэмээний хүүхдийг ботго, адууны хүүхдийг унага гэдэг юм гэхчлэн ярьж, зурж өгөөд, гөлөг бол “Нохойны хүүхэд” гэжээ. Хүү түүнээс хойш гөлгийг “Нохойны хүүхэд” гэдэг болсон юм. Гөлөг хүү үнэнхүү өрөвдмөөр харагдаж байлаа. Үсэнд нь цас шигжээ. Хачин их даарснаас бөмбөгнөтөл чичирч байв. Тэр жижигхэн хар товч шиг хоргол хоёр нүдээрээ Жаалхүүг өрөвдөлтэй ширтэнэ. Биеэ шилгээж, цасаа унагаах ч тэнхэлгүй болсон бололтой. Нүднээс бусад нь ер хөдлөхгүй байлаа.

Чи юугаа хийгээд энд сууж байгаа юм бэ? Ээж чинь хаачсан бэ? Эзэн чинь зодсон уу? Эсвэл төөрсөн үү? Лав төөрсөн байх. Одоо яана даа.

Жаалхүү ийш тийш харав. Хавьд хүн амьтан алга. Салхи хүүгэн үлээж, цасаар шавхуурдсаар байна.

-Юу ч гэсэн би сүүгээ аваад ирье. Удахгүй гүйгээд ирнэ. Чи эндээ л тэсээд сууж байгаарай, за юу? Би худал хэлэхгүй. Заавал чамайг ирж авна. Сууж л байгаарай!

Хүү гөлөгт ингэж хэлээд сүүний саваа сажигнуулан дэлгүүр үрүү жирийлээ. Сүүний тасагт хүн олон байв.

“Яахав? Учраа хэлэх үү? Энэ эмээ, өвөө, эгч, ах нараас гуйх уу? Гуйвал хүмүүс тэр жаахан гөлгийг өрөвдөнө дөө” гэж бодлоо.



Тэгтэл дарааллын эхэнд зогсож байгаа бавгар цагаан сахалтай өвөө "Хүү минь чи нааш ир" гэсэн янзтай, онигор нүд, долоовор хуруу хоёроороо дохин дуудав. Саваа барьсаар гайхан хүрч очвол сайхь өвөө:

-Хүү чи тун их яарч яваа бололтой. Нялх дүү чинь гэртээ ганцаараа үлдсэн үү? Лав угжаа нэхээд уйлж байгаа биз, тийм үү? Өвөөгийнхөө урдуур ороод сүүгээ авч үз! гэв.

Жаалхүү маш их гайхлаа. "Миний яарч явааг энэ өвөө яаж мэднэ вэ?" Том хүмүүсээс юу ч нуух аргагүй. Яасан ухаантай өвөө вэ? гэж бодоод:

- Баярлалаа, өвөө! гэж хэлэв.

Тэгээд сүүгээ авч, нөгөө улиасны дэргэд гүйн ирсэн гөлөг ашгүй байж байлаа. Тэр хүний хэлийг мэдэхгүй боловч хүүгийн үгэнд оржээ. Ухаантай амьтан бүхэн хүний үгэнд ордгийг Жаалхүү мэддэг юм. Тэр гөлгийг "ухаантай учраас намайг хүлээж байв" хэмээн боджээ.

Хэсэг хугацаа өнгөрсний хойно хүү гөлгийг хөвөнтэй цамцандаа боогоод тэвэрчихсэн гүйж явав.

Замдаа "Хэрэв эгчийн үнэгэн лоовуузыг өмсөөд гарсан бол гөлгийг дотор нь хийгээд, чихэвчээр нь даруулан бүчилж, цүнх шиг бариад явж болох байв" хэмээн бодож байжээ. Малгайд багтахаар тийм жижигхэн амьтан юмсанж.

"Чамайг эх чинь голоогүй биз? Яалаа гэж ийм нялх хөөрхөн амьтнаа голоод хаях вэ? Нохой чинь ухаантай амьтан. Тийм биз дээ? Аль эсвэл чи ээж аавгүй юм уу? Чи ер нь өнчин байх. Би өнчрөхөөс их айдаг. Манай байранд нэг өнчин охин байдаг юм. Тэр дандаа уйлдаг. Хүн бүхэн түүнийг өрөвддөг. Аягүй бол чи ч өрөвдөх байх!"

Жаалхүү цамцанд боолттой нялх гөлгөө тэр чигээр нь үүдэн хавьцаа нямбайхан тавиад Должид эмээгийн хонхыг дарлаа. Эмээд гөлгийг үзүүлж болохгүй. Учир нь эмээ нохойд дургүй. Ач нарыгаа нохойтой тоглолоо гэж үргэлж загнана. Гэхдээ ач нартаа хайртай сайн хүн гэдгийг хүү мэднэ.

Нэг удаа ийм явдал болжээ. Эмээгийн ач Төмөр дэлгүүрээс талх авчирна гээд алга болж гэнэ. Должид эмээ хайгаад хайгаад олсонгүй. Хавийн хүүхдүүдээс сураглаад сураг гаргасангүй. Тэгтэл айлын нь зэргэлдээ орцны нэг өвөө Төмөрийг “Маахуур толгойн ард жижигхэн шар нохой хөтлөөд явж байна” гэж хэлжээ. Эмээ таягаа аваад (уг нь таяг тулдаггүй хүн) очсонд ач хүү нь өөр нэг хүүгийн хамт нээрээ нэг шар нохой хөтөлчихсэн, бас жаахан улаан дарцаг барьчихсан явж байжээ. Гайхалтай нь гэвэл эмээ ач хүүгээ биш, мөнөөхөн шар нохойг тоногтой хүнд таягаараа айхавтар сүрхий зоджээ.

(Хожим сонсвол тэр нохой өрөөсөн хөл доголон болсон гэх бөгөөд хүнээс айж зугтаан, эцэст нь Цагаан даваанд гарч зэрлэгшээд, өшрөхдөө айлын мал барьдаг болсон гэнэ билээ.)

Должид эмээгийн энэ жигтэй явдал хавийн хүүхдүүдийн сонорт хүрч, өөрсдийгөө зодуулна гэхээс хайртай нохойгоо жанчуулна гэж айдаг болсон юм.

... Гөлөг чичирсээр л байв. Жаалхүү авчирсан сүүгээ буцалгах гэж цахилгаан тулган дээр тавьжээ. Халуун сүү өгвөл амархан сэхнэ гэж бодсон хэрэг.

- Чи яаж байна? Одоохон халуун сүү өгнө. Наад муухай цас, шороог чинь цэвэрлэнэ. Хуурай даавуугаар арчиж, шороог чинь хатаана. Халуун усанд оруулсан ч болох юм. Манайд халуун ус, саван бий. Ер нь манайд юм бүхэн бий. Аяндаа чи үзнэ ээ.

Толинд харуулж байгаад үсийг чинь самнасан ч болно. Толинд чамтай яг адилхан гөлөг харагдана. Чи гайхна даа. Аягүй бол өөрийгөө танихгүй хуцаж сүйд болох байх. Маргааш гэхэд л ямар хөөрхөн нохой болохоо мэдэж байна уу чи?

Гөлөг чичирсэн хэвээр. Хүү буцалсан сүүнээсээ төмөр тавагт хийж хошуун дор нь тавьсан боловч гөлөг түүнээс нэг удаа ч долоосонгүй.

- Чи ер нь өвчин туссан байх. Халуураад чичрээд байгаа байх. Тийм бол яана? Би чамайг даанч эмчилж чадахгүй. Уг нь хүнийг өвчилбөл халууны шил гэж ийм нэг (хуруугаараа зааж

яриу) гожгор юмыг суганд нь хийгээд халууныг нь үзчихдэг юм. Чиний суга чинь ингэхэд аль юм бэ? За тэгээд их халуурсан бол гашуун амттай цагаан эм өгнө. Чи ч гэсэн халуурсан бол тэр л эмийг ууж таарна. Огихгүй, нүдээ аниад залгичих хэрэгтэй. Би тэгдэг юм. Алив, нүдээ хар! Нүдээ нээ! Хараач дээ! Яая даа байз, чамайг!

Найз чинь дөнгөж хоёрдугаар ангийн сурагч болохоор юм бүхнийг мэдэхгүй байна. Чамд тусалж чадахгүй байна.

Хүн чинь эхлээд яг л чам шиг нялх, юу ч мэдэхгүй амьтан байдаг юм. Би жаахандаа мөн л чам шиг байсан. Ноднинхон хүртэл эмээгээ ёо ёо болчихоод байхад инээгээд гүйж явсан гэлцдэг юм. Миний эмээ ноднин нүд аньсан юм байхгүй юу. Үхнэ гэдэг чинь нүд анихыг хэлдэг юм. Чи яагаад нүдээ аниад байна. Май, наана чинь сүү! Ядаж ганцхан удаа долоо!...

Гөлөг үхсэн мэт унтаж байжээ. Дулаан байранд ороод тийнхүү нам унтсаныг хүү яахан мэдэх билээ.

Тэр гөлгийг "лав осгоод үхэв" гэж бодсоноос зайлахгүй. Чингээд хэрхсэнийг мэдэх гэж жижигхэн сайран хамар руу нь шүүрний өвсөөр зөөлхөн хатгав. Тэгтэл гөлөг дөрвөн магжгар хөлөө татганатал хүчтэй найтаан, гижиг нь хүрсэн бололтой хамраараа тургиж, том далбагар чихээ дэлбэгнүүлэн өндөсхийв. Гэвч дахиад бөөрлөн хэвтүүт, таг чиг боллоо.

-За, за мажийгаагүй бол болох нь тэр. Унтаж байгаа бол юунаас айх вэ. Унт, унт! Манайх дулаахан айл шүү! Удахгүй ээж, ах хоёр ирнэ. Дараа нь аав ирнэ. Эгч бүүр орой ирнэ. Манайхан чамайг ад үзэхгүй. Ад үзэх байтугай мах чанаж, бууз жигнэж ч мэднэ.

Би ер нь чамайг өнчин амьтан гэж хэлье. Үнэхээр ч өнчин юм билүү? Ээ, аав өнчин хүүхдэд хайртай. За энэ ч яах вэ. Хоол идсэний дараа чамд би сонин юм үзүүлнэ. Чи телевизор гэж юу байдгийг мэдэхгүй байж таарна. Телевизээр "Амьтны ертөнц" гэдэг гоё нэвтрүүлэг гардаг юм. Нохой, заан, чоно, сармагчин, могой, ялаа, шоргоолж, зөгий.. гээд л зөндөө амьтан, хорхой

шавж хүртэл гарна шүү дээ. Манай дэлхий дээр хэчнээн олон янзын амьтан байдаг гэж санана. Яасан олон янзын нохой байдаг юм бэ? Би дөнгөж хоёрдугаар ангийн хүүхэд болохоороо бүгдийг даанч мэдэхгүй. Гэвч удахгүй мэддэг болно. Манай ангийн багш Дунгармаа гэж сайн хүн бий. Багш надад зааж өгнө, мэд ээ.

Гөлөг унтсаар байлаа. Дахиад шүүрний хатуу өвсөөр хатгуулахгүй гэсэн шиг нэг хөлөө бяцхан хар хамар дээрээ тавьжээ.

Жаалхүү тооны даалгавраа өчигдөр хийсэн болохоор одоо зөвхөн цээжлэх шүлгээ унших ёстой байв. Тэр номоо нээгээд суусан боловч юу ч үл ойлгов.

“Манайхан чамайг ад үзэхгүй”. Саяхан гөлөгт хэлсэн энэ үгээ бодлоо. Яагаад ч юм айх шиг болов. Худал хэлчихсэн юм шиг гэнэт санагджээ. Должид эмээ шиг зодохгүй ч гэлээ гөлгийг гэрт байлгахгүй гэвэл яана. Хүү ээж, аав, эгч, ах нарыгаа ухаантай, өрөвч зөөлөн сэтгэлтэй хүмүүс гэдэгт итгэж байлаа. Түүний бодлоор, хэрэв тэд ийм сэтгэлгүйсэн бол байрныхаа өнчин охинд хэн бүхнээс илүү хайртай байхгүйсэн билээ.

## ГУРВУУЛАА

Жаалхүү зөв боджээ. Гөлөг авчирлаа гэж түүнийг хэн ч эмлэсэнгүй. Гөлөг өрөөн дотуур баацганан явж байлаа. Хэн хүнгүй:

-Хаанаас олов? Яасан жаахан амьтан бэ?

-Дөнгөж нүдээ нээсэн бололтой юм. Эвий хөөрхий гэцгээнэ.

Тоомой ах нь гөлгийн овоон дээрээс сарвагануулан өргөөд “Сайн нохой болох юм байна” гэж хэлжээ. Нохойн сайн, мууг овоон дээрээс нь юмуу, сүүлнээс нь өргөж шалгадгийг Жаалхүү

мэддэггүй байлаа. Гөлөг сүүлнээс нь өргөхөд ч биеэ дааж, ердөө сандарч сарваганан гасалсангүй. Тэвчээртэй, тайвны шинж ийм байдаг юмсанж.

Энэ айлынхан тэр үдэш гэнэт ирсэн “санамсаргүй шинэ зочныхоо” тухай, ер нь нохойны тухай урьд өмнө сонсоогүй хачин сонин яриа дэлгэжээ.

- Манайх хоёр нохойтой байсан. Нэг нь миний нохой, нөгөө нь хотны нохой. Би өөрийнхөө нохойг “Годой” гэж нэрлэдэгсэн. Сүүлээ үргэлж годойлгож явдаг болохоор нь тэгсэн юм болов уу даа. Годой хүүхэдтэй тоглодог учир мад мэдэхгүй. Голдуу гэрт байна. Хүн зууна гэж үгүй. Яаж ч ноолж байсан тоохгүй. Гэтэл нөгөө хотны нохой “Чанаг” маань айхавтар хэцүү. Хонь мал, гэр бараагаа тэр л харж хамгаална. Гэрт орохгүй. Өвлийн тэсгим хүйтэнд ч гадаа явна. Жигтэйхэн сонорч, айхавтар үнэрч амьтансан. Одоо бодоход тэр, үл таних айлчин гийчин, ялангуяа хээрийн боохой-чононы үнэрийг алсаас мэддэг байжээ гэж ярьснаа аав нь баахан бодолхийлээд цааш үргэлжлүүлэн:

- Монгол нохойд бусад улс оронд байдаг үүлдрийн нохдоос өөр нэг гайхамшигт сайн чанар бий. Юу гэвэл монгол нохой хотоо манахаас гадна мал хариулдаг юм. Би 1950-иад оны эхээр Өмнөговь аймгийн Булган суманд очихдоо улсын аварга малчин Гэндэнсүрэн гэдэг айлын “Хүдэр” нэртэй халтар нохой хонь хариулж явахыг үзсэн. Өглөө эрт хонио дагаад гарна. Орой хамт ирнэ. Хүдэр өглөө хонио гүвээн дээгүүр далдармагц идэж байсан хоолоо дутуу орхиод хойноос нь одно. Ингэж өдөржин хонь дагахдаа айл саахалтын сүрэгтэй огт нийлүүлдэггүй, хэрэв нийлмээр бол дундуур нь хэрж давхидаг, хуцаж үргээдэг байжээ. Тэр ч бүү хэл салхидуулдаггүй, гэрээсээ хол явуулдаггүй, орой нар унийн углуургад тусах үест хонио туугаад ирдэг байв. Гэндэнсүрэн гуай Хүдэрийг хар багаас нь ийм сүрхий малч болгон сургажээ. Дуугий нь бүдүүн, сүрлэг сайхан болгохын тулд багад нь орсон буурны хөөс өгдөг байсан гэж нутгийн ардууд ярьж билээ. Нохойг хоточ, малч, анч болгодог монголчуудын

арга их өвөрмөц сонин шүү гэв.

Жаалхүү бүгдийг ойлгохгүй ч айхавтар сүрхий анхааран чагнасаар байлаа. Харин Тоомой ах нь ярианд идэвхтэй оролцох тул ааваасаа:

- Хэнтий аймгийн анчин Лувсан гуайн нохойн тухай ярьж өгөөч хэмээн шалгаав.

- Улсын тэргүүний анчин Лувсан уу? Түүний түүх, нохдынх нь эрдэм чадлыг ярина гэвэл барагдахгүй дээ. Лувсан чинь 1957-1977 оны хооронд гэхэд л анч нохдынхоо тусламжаар 22 мянган тарвага, 900 чоно, 200 шилүүс, 40 баавгай агнасан хүн. Тэр цэргээс 1946 онд халагдаж ирээд Хумбага гэдэг хүнээс "Тайга" нэртэй азарган нохойг зуун төгрөгөөр, "Жингэр" нэртэй гичийг тавин төгрөгөөр худалдан авсан гэдэг юм. Лувсан гуай анч нохойн шинжийг ярихдаа "Арьс нь сул, өөрөөр хэлбэл хүзүүнээс нь татахад их сунадаг, толгойн яс нь овоо өндөр, чихний холбоос хол, урт шулуун сүүлтэй, бүдүүн дуутай бол сайн" гэдэг байжээ гэв.

Яагаад ч юм Жаалхүүд аавын нь ярьсан сайн нохойны шинж олж ирсэн бяцхан гөлөгт бүгд л байгаа юм шиг санагдаж байлаа.

- Хүүхэд байхад ч нохойд заавал хайртай байдаг юм даа. Би хүртэл нэг жаахан шар хавыг мөн ч их хайрлаж, эрхлүүлдэгсэн. Аав минь түүнийг хотоо мануулах гэж биш, охиноо л эрхлүүлэх гэж хаа байгаа хотоос өвөртөлж ирсэн байж билээ. "Ингэхэд хүүхдүүд ер нь яагаад нохойд хайртай байдаг юм болоо" гэж ээж нь гайхсан, асуусан аялгаар ярина. Жаалхүүгийн аав:

- Нохой бол хүний хамгийн анхны нөхөр. Хонь малаас бүр өмнө хүний асрамжинд ирсэн амьтан. Нөгөө талаар гэвэл бас нэг сонин учир байж болно доо.

Хүүхдийг ухаан ормогц сэтгэлд нь чоно гэсэн нэг айхавтар дайсан бий болдог юм. Чоныг хүүхдүүд ээж, аавынхаа ярианаас буюу үлгэрээс анх түрүүн мэддэг. Ингэж үл үзэгдэгч нэг өштөнтэй болдог байна. Удалгүй үл үзэгдэгч тэр өштнийхөө сургийг хэн

хүнээс сонсдог, сонсоод ч зогсохгүй хор хөнөөлийг нь хотныхоо захаас (чононд бариулсан хонь малын сэг мэтийг) олж үздэг шүү дээ.

Ингэхэд чонотой тэмцдэг, түүнийг айлгаж, буянт мал сүргээ хамгаалалцдаг амьтан юу билээ? Нохой биш гэж үү? Яах аргагүй мөн! Ингээд л хүүхдүүд хар багаасаа нохойд хайртай байна гэдэг чинь угтаа чононд л өшөөтэй байна гэсэн үг. Хүүхдүүдэд маань хайрлах, өших юм заавал байх ёстой биз дээ? гэсэнд хүүгийн ээж:

- Мэдээж. Гэвч "Нохойг хайрла, нохойтой тогло" гэж би л Жаалхүүдээ хэлээгүй шиг санагдах юм гэв.

- Би ч тэгж шаардаагүй. Гэтэл энэ маань гөлөг тэврээд иржээ. Гайхал чононоос болсон юм болов уу даа, гэснээ инээмсэглээд:

- Одоо яахав. Уг нь нийтийн орон сууцанд нохой тэжээж болохгүй гэсэн хотын захиргааны шийдвэр бий. Тэгээд ч элдэв золбин нохдоос хүн, малд халддаг өвчин байдаг. Яадаг билээ дээ, гэв. Ээж нь:

- Яая гэхэв. Дүн өвлөөр ийм нялх амьтныг хөлдүү гудамжинд хөр цасан дээр гаргаад хаялтай биш гэжээ.

Жаалхүү ээждээ хэчнээн их баярласан гэх вэ! Аавдаа ч гэсэн яахин баярлахгүй байх билээ.

- Юу ч гэсэн өвөлжүүлье. Нохой хүнтэй хамт байхдаа жаргалтай боловч, хүн нохойтой цуг сууна гэдэг бас ч амаргүй. малчин айл бол өөр хэрэг. Гэхдээ л хүү минь малчид чинь хоточ нохдыг гэртээ биш, хотныхоо захад, бүр товгор сэрүүн газар хэвтрийг нь засч байлгадаг заншилтай юм шүү дээ гэж аав нь хэлээд:

- Хүү минь одоо нохойдоо нэр өг! гэжээ. Тэгээд бас:

- Нохойн нэр богино, тод сонсдох үг байдаг.

Монголчууд нохойд голдуу "Хойлог", "Банхар", "Хасар", "Басар", "Нянгар", "Бүргэд", "Барс", "Баатар" гэх мэт нэр өгдөг юм даа гэж зөвлөв.

Гөлөгт ямар нэр өгөх тухай бөөн яриа боллоо. Зарим нь зүсээр, зарим нь ааш зангаар нэрлэе хэмээн янз янзын нэр хэлсэн боловч эцэст нь Жаалхүүгийн саналаар “Даагаа” гэж нэрлэжээ. Аав нь хүүгийнхээ санааг мэдээд:

-Даага шиг том нохой болоорой гэж ерөөлөө.

Даагаа алив нялх томоогүй амьтны зангаар нэрээ ч мэдэхгүй, тун төрхгүй загнаж байжээ. Галын өрөө үрүү ордог хонгилын буланд жижиг эсгий дэвсэж, хэвтрийг нь зааж өгсөн боловч тэндээ тогтоно гэж үгүй. Хаагуур хамаагүй гүйх гэнэ. Тэгэхээр нь дэлгүүрээс том цаасан хайрцаг авчирч, цонх гаргаад, дотор нь хийв. Чингэтэл цонхоор толгойгоо цухуйлган, хайрцагтайгаа хамт тонгорцоглон унаад болсонгүй.

Сул байлгахаас өөр аргагүй боллоо. Унтахаасаа бусад цагт идэж, эрхлэх гэнэ. Тавьж өгсөн хоолтойгоо эрхэлнэ. Ширээ сандлын хөл мэрнэ. Өдөр сараар өсч “Шүд нь ургах гэж загатнаж байна уу” хэмээн бодоод түүнд мөлжүүртэй булуу хаяж өгдөг байлаа. Булууг мэрэхээсээ хол өнхрүүлэн, хойноос нь үсрэн барьж зугаацна.

Харахад энэ бүхэн зугаатай боловч аргалшгүй эрх, зүггүй нэг жаал энэ ам бүлд нэмэгдсэнээс доргүй ажил удах боллоо. Хөнгөн хөгжим юмуу, байлдаантай киноны дууг сонсохоороо телевизор уруу сүүлээ өргөж, чихээ босгож байгаад унгас алдан хуцна. Ер нь түүнийг тусгай дэглэмд сургахгүй бол горьгүй болсон үед ийм нэг санал гарав.

- Даагааг үнээ малтай, эсвэл хашаатай айлд өгвөл таарна. Манайд нохойны хэрэг юу билээ. Тэгээд Жаалхүүгийн хичээлд садаа болох биш үү. Энэ саналыг Дашиймаа эгч нь хэлжээ. Шөнө хичээлээ давтаад сууж байхад нүцгэн шилбийг нь долоож хоёр ч удаа унатал цочоосон болохоор Даагаад тэр сайнгүй болсон байж мэднэ. Яагаад ч юм охиныхоо саналыг аав дэмжсэнгүй.

- Юу ч гэсэн өвөл өнгөрөг дөө гэсэн нөгөө л үгээ хэллээ.

Харин маргааш өглөө Даагаад улаан бүрээстэй дээсэн хүзүүвч хийж, хуучин унадаг дугуйны гинжээр түүнийг оосорлоод



гадагш авч одов. Хотын мал эмнэлэгт аваачиж шинжилгээ хийлгэх, тусгай номер авах гэж явсан нь тэр ажээ.

Ингэж Даагаа эрүүл мэндийн бичигтэй, хэн нэгний эзэмшилд байгаагийн тэмдэг болсон баталгаа пайзтай болоод хотын дулаан тохилог байранд өрөвч сайхан сэтгэлтэй хүмүүсийн хамт амьдрах болсон билээ.

Аав, ээж, ах, эгч нараа ажил сургуульд явсан хойгуур Жаалхүү нохойгоо авч гадагш гарна. Тэр даруй хүүхдүүд шаваад ирнэ. Даагаа ч багачуулын хайрыг татам хөөрхөн нохой болжээ. Улаан хүзүүвчтэй, хүзүүвчиндээ төмөр пайзтай, гинжин уяатай, хоёр чих соотон, сүүлний нь үзүүр сүүнд дүрсэн юм шиг цагаан, гялталзсан хар зүстэй, хэн бүхэн үрүү асч авирсан амьтан.

Нүд нь бөв бөөрөнхий, хамрынхаа сайран үзүүр шиг хав хар. Бяцхан сүүлээ цаг үргэлж дээш модойлгож явна. Сүүлээ ямагт өргөж явна гэдэг нохойныхоо хувьд хэнээс ч, юунаас ч айдаггүй, омог бардам байгаагийн шинж юм аа. Бас хар хоргүй, аюул хөнөөл хаанаас ч ирэхгүй гэж итгэсэн цагаан цайлганы гол тэмдэг нь юм. Даагаа үнэхээр хүмүүст, тэр тусмаа жижигхэн хүмүүст (хүүхдэд) итгэдэг байлаа. Арга ч үгүй биз. Эхлээд түүний харсан зүйл нь хүүхэд гэгч хоёр хөлтэй, богинохон босоо амьтан. Бээрээд үхэх гэж байхад дулаан газар авчирч, бүлээн юм амсуулсан амьтан бол хүүхэд юм. Тэр эхийгээ ч бараг мэдэхгүй байх нялх үедээ хүний үртэй ийнхүү учирч билээ. Тийм болохоор хүүхдэд хайртай байхаас яахав.

Хэрэв Даагаа хүний хэл мэддэгсэн бол бишгүй их юм ярих байсан биз. Гэхдээ л ухаантай нохой ямар ч аргаар хүмүүст баяр талархлаа илэрхийлж чаддаг гэхэд болно. Чихээ хөдөлгөвөл “Таны үгийг сонсоход бэлэн” гэсний тэмдэг, сүүлээ хөдөлгөвөл “баярлалаа” гэсний шинж юм.

Ер нь нохой хүнтэй ойр байдаг болохоор хүний ухаанаас, бас ая зангаас нь жаахан ч гэсэн олз олдог байж мэдэх юм. Хүний бараа харахгүй чоно мэт араатан амьтад юутай догшин ааш зантай, хүнээс хэчнээн их төсөө байдаг билээ дээ. Хүнтэй хамт

амьдардаг болсон учраас л нохой өөрийн төрх болох чононоос салж чадсан биш гэж үү? Тэр ч байтугай гайхал чононоос хүний амьдралыг өмгөөлдөг болоогүй гэж үү? Тэгэхээр хүн ч бас нохойгоо эргээд чонын сүрэгт нийлүүлчихгүйн тулд тэднийг хайрлаж хамгаалах хэрэгтэй биз ээ.

Жаалхүү энэ бүхнийг ухаарах насандаа хараахан хүрээгүй байлаа. Даагаа бол хэзээ ч мэдэх аргагүй. Хэчнээн том болж, өссөн ч түүнийг ухаарч чадахгүй. Тэр одоогоор хүүхдийн дотор муу хүүхэд, хүмүүсийн дотор олиггүй муу хүн байдгийг ч бас мэдэхгүй л гүйж явна. Айл зэрэгцээ “нимгэхэн хананы цаана” амьдран суудаг Должид гэгч эмээ таягаараа хүмүүст, хүүхдүүдэд хайртай, тэдэнд итгэдэг нэг нохойны хөлийг хуга цохиж гэмтээсэн, тэр нь зэрлэгшээд ууланд дайжсан түүхийг ч мэдэхгүй юм.

Өөрөөр хэлбэл эрхлэхээс өөрийг үл бодно. Түүнд найзлах жаалууд мундахгүй байлаа. Гэвч эзнийхээ зааврыг дагах ёстойгоо тэр, нохойн зөнгөөрөө бас мэддэг ажээ. Жаалхүү хамгийн түрүүнд Даагааг Үзмээтэй танилцуулсан юм. Үзмээ бол нөгөө өнчин охин. Ээж, ааваа өөд болсноос хойш тун чиг уйтгартай явдаг болсон хүүхэд. Жаалхүүтэй нэг ангид сурдаг болохоор тэднийд үргэлж шахам ирнэ. Хүүгийн ээж аав ч түүнд туслахыг хүүдээ зөвлөнө. Тийн Үзмээ охин гэрийн даалгавраа Жаалхүүтэй хамтарч хийгээд, эцэст нь Даагаатай тоглодог болжээ. Үүн шиг зугаатай тоглоом Үзмээд үгүй болжээ. Даагаад ч гэсэн өөрцгүй. Чухамдаа түүнийг хүмүүст баяр хүргэж хөлөө өгөх буюу уучлал хүсч хойд хоёр хөл дээрээ сууж сургасан хүн бол зөвхөн Үзмээ л юм.

Жаалхүүг бодоход уянгалаг хонгор дуутай, энхрий зөөлөн гартай энэ охиныг Даагаа хүрээд ирээсэй гэж мөрөөддөг болжээ. Хонх дуугармагц үүд үрүү үсрэн очиж самардана. Түүнийг үнэрээр нь амархан танина.

Үзмээгийн үнэр андашгүй. Ер Жаалхүүгээс үргэлж шахам ханхалдаг шоколад гэгч амтлаг хүрэн зүйл буюу ой гутам

зэвүүн хурц сармис, сонгино хэмээх өвсний үнэр Үзмээгээс үнэртэхгүй.

Харин өөрийнх нь үүрч ирдэг ширэн сав, түүн доторх нимгэн цагаан хуудаснуудын (дэвтэр, номын) өвөрмөц содон үнэр л үнэртэнэ. Даагаа Үзмээтэй танил болсноос хойш хүүхдүүдийг 2 бүлэгт эрэгтэй, эмэгтэй гэж хялбархан ялгаж таньдаг болсон юм. Энэ нь нохойн хувьд том нээлт байлаа.

Эелдэг дуутай, зөөлөн гартай, сайхан үнэртэй, тод өнгөтэй хүүхдүүд бүгд Үзмээтэй адилхан атал өөрийг нь төдийлөн тоохгүй, эрхлэх дургүй, тэр ч бүү хэл зугтаах нь нэн харамсалтай.

Харин хахирган дуутай, ширүүн гартай, түргэн хөдөлгөөнтэй, хурд ихтэй жаалууд, түүнтэй цуг байхыг ямагт эрмэлзэнэ. “Ширүүн гартнууд”-ыг Жаалхүүгийн төрөл гэж Даагаа сайн мэднэ. Үнэндээ Даагаа Үзмээгийн үнэр, хөдөлгөөнөөр нэг хэсэг хүүхдийг, Жаалхүүгийн үнэр, хөдөлгөөнөөр нөгөө хэсэг хүүхдийг ялган таньдаг болсон байж болох юм. Хэрэв энэ үнэн бол Үзмээ охин Даагаад мөн ч их юм ойлгуулсан байж таарна даа.

## ДӨРВҮҮЛЭЭ

Даагаагийн дараачийн танил нь хажуугийн айлын Болдбаатар гэгч хүү юм. Болдбаатартай сайндаа ч танилцсангүй. Ер нь хэнтэй танилцаж болох, хэнтэй нь болохгүйг эзэн мэднэ. Нэг удаа Жаалхүү Даагаа хоёрыг гэрээсээ гараад шатаар уруудаж явахад Болдбаатар тааралджээ. Жаалхүү ангийнхаа найзаас баахан зовсхийв. “Багшид ховлох байх” гэж бодсоноос зайлахгүй. Болдбаатар хэдий гэртээ ганцаараа үлддэг боловч гадуур тэнэдэггүй, Жаалхүү шиг сүү, талханд ч явдаггүй, үүдээ дотроос нь түгжээд л сууж байдаг хүүхэд. Түүний хэдэн цагт нойрноос сэрдэг, жижиг явган сандлуудаа түжигнэтэл

чирэн, гэрээ цэвэрлэдгийг гагцхүү чимээгээр нь мэдэх төдий. Тийм болохоор тоглож, дотно үерхсэн удаагүй ажээ. Тоглож, үерхдэггүй хүүхдүүд бие биеэ мэдэхгүй, мэдэхгүйгээр ч зогсохгүй хэн хэнээсээ айж цэрвэдэг юмсанж.

Болдбаатар яагаадыг бүү мэд Даагааг хараад зогтусан ойртов. Дараа нь “Яасан хөөрхөн гөлөг вэ! Чинийх үү?” гэж шалгаасан царайгаар Жаалхүү үрүү харлаа.

Даагаа эзнийхээ юу хэлэхийг хүлээж, шатны гишгүүр дээр томоотойхон сууж байв. Чингэтэл Жаалхүү;

- Найз аа! Бид хоёртой чи тоглох уу? Миний Даагаатай танилцахгүй юу? гэж зориглон асуужээ.

- Үүнийг чинь Даагаа гэдэг юмуу? Хөөрхөн нохой байна... гэснээ Болдбаатар “Аав, ээж загнах байх” гэсэн байртай хараад гэртээ орчихлоо. Гэвч хүү тэвчиж чадсангүй, Жаалхүү Даагаа хоёрыг гадаа хүүхдийн тоглоомын талбайд очиж явахад хойноос нь гүйж иржээ. Ингээд л тэд танилцсан хэрэг. Эхлээд Жаалхүү нохойныхоо гинжийг савлах аятай хөдөлгөөд,

- Болно, болно гэж хоёронтоо давтан хэлэв. Энэ бол “Танилцаж болно” гэсэн үг. Даагаа “болно” гэсэн үгийг анх түрүүн Үзмээтэй танилцахад сонсож билээ. Өнөөдөр зөвшөөрлийн тэр сайхан үгийг сонсуут шинэ найздаа баруун хөлөө өргөн өгөв. Хүү хариуд нь гараа бас өгөөд:

- Болдбаатар гэж нэрээ хэлэв. Даагаа “Хэн гэнээ” гэсэн шиг ерөөсөн чихээ өргөн хүүгийн нүүр үрүү гилжийн харна.

- Болдбаатар. Зүгээр л “Болдоо” гэж хэл! Нохой хоёрхон үетэй үгэнд дуртай байдаг юм. Чиний нэрийг заяа нь тогтоохгүй.

- Болдоо!

- Даагаа, таатай байгаагаа илэрхийлэн, сүүлээ хөдөлгөлөө. Түүнийг шинэ найзтай болж, бас нэрийг нь санаж буйг Жаалхүү тэр даруй тааварлаад баахан сайрхах дур хүрч:

- Харж байна уу? Одоо чамайг таньдаг болох нь энэ. Сүүлээ хөдөлгөөд, ингэж цовхрохоор л нэрийг чинь тогтоочихлоо гэсэн үг гэж хэлэв.

Үүний үнэн, эсэхийг хэн мэдэх билээ. Гэхдээ л Даагаагийн ая занг хэн хамгийн сайн ойлгох билээ? Мэдээж, Жаалхүү л шүү дээ. Малын занг малчид л илүү мэддэг юм. Үүнчлэн нохойтой тоглодог хүүхэд нохойн ааш занг, тэр ч бүү хэл хүсэл бодлыг нь хүртэл андахгүй мэддэг болдог хэрэг. Хэрэв зээ араатан сургадаг болж гэмээ нь хүүхдүүд бас араатны аашийг таньдаг болно доо.

Хоёр хүү Даагааг дагуулаад гүйж явлаа. Чингэтэл араас нь “Хүүе, Жаалхүү” гэж дуудах сонсдов. Халтар ажээ. Жаалхүү Халтарт дургүй. Яагаадыг сайн мэдэхгүй. Дургүй бол дургүй байхаас яахав. Таалагддаггүй хүүхдэд хайртай болох хүртэл асар хол зай байдаг. Эсвэл хариугүй жижигхэн хугацаа шаардагдах саад байдаг байж болох юм. Жаалхүү мөрөн дээгүүрээ эргэж хараад хойноосоо гүйж яваа хүүг хэн болохыг танимагц Даагаадаа:

- Үгүй! гэж хэлэв. “Үгүй” гэдэг энэ үг, эзний нь огцом дугтрахтай нийлэхээрээ “Цагаан сүүлт годгорхон минь шалав түргэн холдъё...” гэсэн дохио болно.

“Цагаан сүүлт годгорхон!” Үүнийг Даагаа мэдэхгүй. Мэдэх ч арга байхгүй. Түүнд уг нь “Даагаа” гэсэн нэр өгснөөс “Цагаан сүүлт” ч юмуу, үгүй бол “год-гор-хон” хэмээн нэрлэвэл зохилтой байжээ. Яагаад гэвэл Даагаа сүүнд дүрсэн юм шиг цагаан сүүлтэй, тэгээд сүүлээ цаг үргэлж годойлгож явдаг шүү дээ. За энэ ч яахав. Жаалхүү Даагаад нэлээд хэдэн үг зааж өгсөн юм.

- Болно гэвэл хэн нэгэнд хөлөө өгч болно гэсэн үг, “үгүй” гэж хэлээд гинжнээс нь огцом татвал “энэ хүүхэд муу, түүнтэй найзлахын хэрэггүй” гэсэн үг, аа харин “хэвт” гэвэл “Жаахан хүлээж бай! Удахгүй гадаа гарч тоглоно.” гэсэн дохио гэдгийг Даагаа сайн мэднэ. Халтар тэднийг хэдхэн харайгаад гүйцэж ирэв. Тэр “Долоон онгорхой” хочтой жаал. Нүд том, чих дэлдэн, хамрын нь самсаа хэн хүнийхээс сартгар, ам нь бүр ч том. Энэ удаа гүйж амьсгаадсанаас ч тэрүү, “Долоон онгорхой” нь зэрэг зэрэг онголзож байлаа. Хүн ер нь хүмүүст сайн харагдахгүй

бол нохойд ч гэсэн эвгүй харагддаг байж мэдэх л юм. Даагаа “Би айж байна” гэсэн байдалтай гасалж байлаа. Нөгөө талаар тэр бас нэг эвгүй үг сонсчээ. Халтар! Алив, түргэн зугтаая гэж Болдбаатарыг түрүүн хашгирахад Даагаа бүр ч их гайхсан аж. Учир юу вэ гэвэл Даагаа “Халтар” гэдэг нэг нохойг мэдэхээс биш тийм нэртэй хүүхдийг мэдэхгүй юм. Хамгийн гол нь том сагсгар сүүлтэй, нойтон шүлхий амтай, “Халтар” хэмээх тэр гайхал азарган нохой их дээрэлхүү бөгөөд дүү нохдыг ямагт үл тоох нь түүнд таалагддаггүй болой.

Энэ удаа тэр муу шүлхий нохойг ирж явна уу гэтэл, харин үл таних хүүхэд гүйж иржээ. Хэдий тийм боловч Даагаа Халтарт тал өгсөнгүй. Нэрнээс нь болсон байж болох юм даа. Даагаа Жаалхүүгийн араар орж, Болдбаатарын хөлийг шөргөөн зогсоно. Тэр “Энэ чинь муу жаал байна явъя. Бушуухан холдъя” гэж тэсгэлгүй “шаардсаар” байлаа. Үүнийг Жаалхүү ойлгож байв.

- Бацаанууд аа наадах муу гөлөгөө надад өг!

- Үгүй!

“Үгүй” гэдгийг Даагаа сайн мэднэ. Болохгүй юм болж байна. Эзэн маань үүнтэй танилцах хэрэггүй, хэзээ ч хөлөө өгч болохгүй гэж хэлж байна гэж ойлгожээ.

- Юу гэнэ ээ, муу нусгай! Тэгэхдээ тулбал наад муу гөлгийг чинь тасчаад хаячихна шүү. Нэг мэдсэн Даагаагийн толгойг ёстой л үсэрч унамаар огцом хүчтэй угзрав. Хоолой нь битүүрч нүд нь эрээлжлээд явчих шиг болжээ. Тэр гасалж байлаа.

- Явъя! Зугтаая! Даагааг дахиад хүчтэй угзрав. Золтой л ухаан нь балартаж ойчсонгүй. Нялх амьтан болохоор яах билээ. Гэвч тэр “муу нөхрөөс хамаг хэрэг үүсч байгааг” дорхноо мэдээд авчээ. Нохойн төрөлхийн ааш хараахан хөгжөөгүй болохоор хэрхэн эсэргүүцэж чадах билээ. Нүдээ нээхээс эхлээд хүнтэй хамт байсан учир зуух, хазах мэт муу занг сурсангүй. Ядахдаа хэд хоног хөдөө хээр бусад ноходтой цуг амьдарч үзсэн сэн бол өөр байж мэдэх л шүү дээ.



Тэр өдөр хэнтэй ч эрхлэх дургүй байлаа. Хэдийгээр гайхал Халтар явж одсон боловч цаанаа л гунигтай, хамаг бие нь чичирсэн хэвээр ажээ. Болдбаатар Жаалхүү хоёр ч гэсэн гэртээ орохоос аргагүй болов. Тэд Жаалхүүгийн дорж хэсэг зуур чимээгүй суулаа. Болдбаатар гэрээсээ зүссэн хиам авчирч Даагаад өгсөнд идсэнгүй. Нүд нь цаанаа л нэг уйтгартай, нойтон байна. Уйлж байсан байж ч мэдэх юм. Нохой дотроо уйлдаг байж болох юм.

- Чи уйлж байгаа юмуу даа. Хэрэв тийм бол хэрэггүй. Гомдох хэрэггүй. Бидэнд ерөөсөө гомдож болохгүй. Чамайг дахиад тэр муу Халтар гэдэг хүүхэдтэй уулзуулахгүй.

Жаалхүү ийн ярьсаар байлаа. Болдбаатар ч гэсэн ярьж байжээ. "Аав, ээжээ санаж байгаа байх. Ээжийгээ чи таних уу? Ээжтэйгээ нэг удаа ч гэсэн уулзвал баярлана даа. Би Жаалхүүд чинь хэлье. Чамайг хөтлөөд хотоор эрье. Ээжий чинь олъё. Хэрэв зээ олвол эзэн чинь чамайг сул тавьж магадгүй." Болдбаатар энэ бодлоо Жаалхүүд хэллээ.

- Даагаагийн ээжийг явж эрье. Үүнийг эхэд нь өгье гэсэнд Жаалхүү:

- Юу ч гэсэн маргааш больё гэжээ.

Чингээд нээрээ маргааш өглөө нь хоёр хүү Даагаагаа хөтлөөд гэрээс гарч билээ. Тэд Даагааг анх олсон нөгөө хэдэн улиасны дэргэд хүрч очив. Тэндээс ээжийнхээ үнэрийг авч болно гэж боджээ. Энэ нь бяцхан Даагаад хэтэрсэн сорилт байсныг хэлээд яахав. Хоёр хүү Маахуур тийш явлаа. Хаа нэгтээ нохой гүйж яваа харагдвал тийшээ гүйнэ. "Гүй" гэж хэлээд гинжнээс нь дугтрахад Даагаа ч баярлан гүйв. Сүүлээ өргөөд гүйв. Хэдийгээр ээжээ эрж явааг мэдэхгүй боловч өчигдрийг бодоход хөгжилтэй сэргэлэн байлаа.

Болдбаатар Даагаагийн ээжийг танина гэж итгэжээ. Учир юун гэвэл түүний ээжийн сүүлний үзүүр цагаан байх ёстой гэж бодож байв. Харамсалтай нь тийм нохой тааралдсангүй. Харин хоншоор нь цагаан хар нохой тааралдав. Ямар ч хүзүүвч, пайз



тэмдэггүй тэр нохой Даагааг хараад байлаа. Даагаа ч харж байв.

- Энэ мөн дөг шүү. Адилхан хар зүстэй. Хошуу нь цагаан байна. Заавал сүүлний нь үзүүр адилхан байхгүй байж болно. Тийм үү, найз аа?

- Үгүй ээ, цаадах чинь эр нохой байна.

- Нээрээ юу?

- Чи хар л даа.

Хоёр хүү цааш явав. Тэгтэл бас буцмаар санагдаад болж өгсөнгүй. "Ээж нь биш байг гэхэд аав нь байсан ч юм бил үү. Тэр нохой яагаад Даагааг маань хараад байсан бэ?" гэж боджээ. Хоёр хүү нөгөө газраа хүрч ирсэнд сайхь цагаан хоншоорт нэгтээ зайлж одсон байжээ.

Чингээд тэдний эрэл бүтэмжгүй болж, эрхгүй гэрийн зүг буцав. Харин замдаа танил хүүхдүүдээс нэг сонин юм сонслоо. Аав нь кино үйлдвэрт ажилладаг нэг хүү, Даагааг ихэд сонирхон:

- Наадахаа кино үйлдвэрт аваачиж өгөөч. Киноныхон яг ийм жижигхэн гөлөг эрээд байгаа юм гэжээ.

- Яах гэж тэр вэ?

- Кинонд тоглуулах гэж л тэр байхгүй юу даа. Пуужинд суулгаад хөөргөх юм. Хүүхдийн кино хийж байгаа юм гэнэ лээ.

- Ямар пуужин? Жинхэнэ үү?

- Яалаа гэж хуурамч байх вэ? Ёстой пуужин. Агаарт нисдэг...

Жаалхүү Болдбаатар хоёр бие биенээ харав. Тэдэнд дав даруй сонин сайхан бодол төржээ. "Лайка" нохой шиг Даагаа маань сансарт аялах ч юм билүү? Тэгвэл юутай гоё вэ?"

- Чи үнэнээсээ ярьж байна уу, эсвэл молигодож байна уу? гэж Жаалхүү долоовор хуруугаа асуултын тэмдэг шиг махийлгаад нөгөө хүүхдийг шалгаж эхлэв.

- Энэ бол бат! гэж хэлээд киноны ажилтны хүү "үнэмшинэ үү, байна уу, өөрсдөө мэд!" гэсэн байртай яваад өглөө.

- Яахав? Одоо хоёулаа кино үйлдвэр дээр очих уу?

- Харин ээ? Очоод хэнтэй уулзах вэ?

- Ингэж ярилцаад Жаалхүү Болдбаатар хоёр “Монгол кино” үйлдвэр дээр хүрч иржээ.

Ажил тарж байсан цаг. Хүмүүс том шилэн хаалгаар, уван цуван гарсаар байв. Даагаа юу болж байгаа, яах гэж энд ирээд байгаадаа гайхаж буй бололтой хэн хүн үрүү ээлжлэн ээлжлэн харна. Тэгтэл гэнэт:

- Хөөе, Дооров! гэсэн дуу гарав. Үзвэл том гаанс зуусан, духан дээрээ сар хэлбэртэй бүдэг сорив бүхий нэг хүн хол хол алхсаар сайхь гурав дээр ирэв. Тэр хүнийг “Дооров” гэдэг юм байна гэж Даагаа мэджээ.

- За, банди нар юу гэж явна?

Хоёр хүү инээмсэглээд, үнэн учраа хэлж зүрхлэхгүй зогсоно. “Сайн хүн байна, үүнээс айх хэрэггүй юм” гэдгийг, түүний цаанаа л дулаахан царайгаар нь мэдээд Даагаа сүүлээ шарван, цомцойж суув.

- Ахаа! Та..., та... танайд кинонд тоглох жижигхэн гөлөг хэрэгтэй юу?

Энэ сацуу нөгөө “Дооров” гэгч толгойгоо хөдөлгөн хүд хүд хөхрөөд Даагаагийн нурууг дагуулан илбэснээ, хоёр хүүд хандан нэг юм хэлэв.

- Нааш ир! Та нарыг найруулагчтай уулзуулж өгье гэж хэлснийг Даагаа хэрхэн ойлгох билээ.

Хэдхэн мөчийн дараа Жаалхүү Болдбаатар хоёр нохойгоо хөтлөөд гэрийн зүг урамгүйхэн буцаж явлаа. Тэд хожимдсон байжээ. Кино үйлдвэр “Од холгүй” хэмээх кино хийж байгаа, гөлөг эрж байсан нь үнэн байв. Найруулагч өөр гөлөг олоод саяхан зураг авахаар хөдөө явчихсан ажээ.

Одоо яая гэхэв. Азгүй л байна даа. Үгүй ээ үгүй, чи бол азгүй нохой биш. Худлаа хэлсэн юм шүү. Чи бидэнд битгий гомдоорой. Сансарт бүх нохой нисдэггүй юм. “Лайка” гэсэн нэг нохой л ниссэн. Хүн ч гэсэн ялгаагүй. Олон хүнээс хамгийн мундаг зоригтой, эрдэмтэй, эрүүл хүн л сансарт аялдаг юм.

Ердөө чиг азаар болохгүй. Багаасаа оролдох хэрэгтэй.

- Үнэн шүү! Дунгармаа багш “Энэ удаа ганцхан монгол хүн сансарт нислээ. Холын ертөнцөд аялах гэж туршиж байгаа юм. Хожим ганц хоёроороо бүү хэл хорь, гучаараа аялан жуулчлах болно. Одооноос хүүхдүүд минь биеэ бэлтгэж, биеийн тамир хий, хичээлдээ онцсайн сур” гэж хэлсэн. Хүн олноороо од гарагт аялахдаа нохойг байтугай хоттой хонио аваад нисэх болно гэж нэг зохиолч ярьсан шүү!

Даагаа сүүлээ хөдөлгөн баяртай гүйж явлаа.

## ТАВУУЛАА

Даагаатай тоглох гэсэн хүүхэд улам олон болов. Түүнийг жирийн нэг нохой биш, юм сурах ухаантай нохой гэдэгт хүүхдүүд итгэжээ. Тэгээд ч тэр үү, үзсэн кино, уншсан номоо дуурайж, нохойтой хамт сайн үйлс бүтээх хүслэн тэдэнд төрдөг бололтой. Жаалхүүгийн аав, ээжийг ажилдаа явахыг анаж байгаад оройн ээлжийнхэн тэднийд гүйж ирнэ. Хонх жингэнүүлж, хаалга нүдэн:

- Хөөе, Жаалхүү! Нохойгоо аваад гараад ир! гэх буюу үгүй гэвэл:

- Тэгвэл Даагаагаа өг! Жаахан тоглоод авчирч тушаая гэж шалгаана. Нэг хэсэг нь өдөржин утасдана. Цонхон дороос шүгэлдэнэ. Жаалхүү тэр бүхэнд Даагаагаа өгч тоглуулдаггүй байлаа.

“Хүүхэд бүртэй эрхэлж болохгүй. Ялангуяа Должид эмээгийн ач хүүтэй тоглох хэрэггүй. Эмээ нь чамайг зодно. За тэр Халтартай бол ер болохгүй. Чи Халтарын үнэрийг авбал зугтааж байгаарай. Миний үгэнд ороорой. Чи одоо том болсон. Үзмээ, Болдоо нартай л тогло! Бас нэг сайн найз зааж өгөө.



Жимбиймоллом гэдэг юм. Чи зүгээр л Жимбий гэж байгаарай. Жимбий бол улсын циркийн нохой сургагч, мундаг жүжигчин хүний хүүхэд шүү. Чамд янз бүрийн эрдэм зааж өгч ч мэднэ. Ингэхэд чи ер нь бидэнтэй тоглоод л өдрийг өнгөрөөгөөд байж болохгүй за юу? Заавал юм сурах хэрэгтэй!” Жаалхүү нохойдоо ингэж хэлдэг байлаа.

Хаврын урь орж, нохой байтугай хүмүүсгэрт тогтохоо больсон цаг сан. Жаалхүү “Өнөөдөр чамайг Жимбийтэй танилцуулна. Тэр хүү чамайг удахгүй цирк үзүүлнэ гэсэн. Циркэд олон нохой байдаг юм. Би одоо хичээлээ давтлаа. Удахгүй Үзмээ ирнэ. Чи одоо хэвт” гэж хэлээд ширээнээ тухлан суув. Даагаа “Үзмээ”, “Хэвт” гэсэн үгийг сонсуут хэвтэр тийшээ уйтгартайяа явлаа. Төдөлгүй Үзмээ орж ирэв. Тэр сурсан заншлаар Даагаагийн нурууг тууш илээд нөгөө л уйтгартай ажилдаа шамдан орох нь тэр.

Гадаа хүүхдүүд шуугилдсаар... Даагаагийн тэсвэр алдран, чих нь сортолзож, сүүлээ хөдөлгөнө. Нохойн сүүл хөдөлнө гэгч нэг бол эзнээсээ хишиг горьдсоных, үгүй бол баяр талархлаа илэрхийлснийх бөгөөд гол нь тэсвэр алдаж буйн тэмдэг гэдгийг Жаалхүү Үзмээ хоёр сайн мэдэх тул “Даагаа хэвт” гэж дахин шаардав.

Гасалж, гийнавал бүр ч тэвчихээ больж буйн шинж юм. Даагаа заримдаа халаглан гийнаж, өрцөөрөө шалан дээгүүр гулган мөлхөж ирээд эзнийхээ хөлийг шөргөөдөг зантай. “Шалавхан гаръя” гэж байгаа нь тэр юм.

Даагаа энэ удаа урд хоёр хөлөө зэрэгцүүлэн жийж, дээр нь хүзүүгээ сунган тавиад найз хоёрыгоо нүд цавчилгүй ширтэн, тэвчээртэйгээ хэвтэж байлаа.

“Хүний ёс яасан хатуу дэг журамтай, хэчнээн их баян билээ” гэсэн янзтай харж хэвтэнэ. Жаалхүү Үзмээ хоёр нөгөө л хачин үнэртэй гожгор юмаа барьж, цагаан хуудаснууд дээр үл мэдэх мөр, зураас гаргасаар байгаа бололтой. Даагаа мөр, зураасны учрыг мэдэхгүй. Хэдэн өдрийн өмнө тэр аанай л уйдахаараа

эзний ширээний хөндөл дээр хөлөө тавиад өнгийн үзвэл нэг хуудсан дээр сүүлээ өргөсөн нохой бий болсон байлаа. Яах аргагүй нохой. Гайхалтай нь тэр нохойноос ямарч нохойн үнэр үнэртсэнгүй. Харин гожгор хар юмны үзүүрээс гардаг ер бусын үнэр л сэнгэнэж байжээ. Даагаа хэдий нохой боловч Жаалхүү Үзмээ хоёрын гарт байдаг тэр гожгор зүйл “юуг ч бүтээж” чаддагийг мэдээд авчээ.

Хоёр найзаа удаан суусны дараа хэрхдэгийг Даагаа мэднэ. Тэд хийж байсан бүхнээ хураан авч, арьсны үнэртэй бяцхан саванд хийгээд, гялгар зүйлийг дарж торхийтэл дуугаргана. Энэ сав, мах ногооны үнэргүй тул бусдаас амархан ялгагдана. Гэвч нөгөө Халтарын тийм савнаас хиншүү ханхалж байсныг Даагаа анзаарчээ. Хэл мэддэг байгаад, хэрэв Жаалхүүгээс асуусан бол “Боорцог” гэж хариулах байсан биз.

Ашгүй, найз хоёр нь ширээнээс босов. Даагаа ч баярлан босов. Эзэн нь худал хэлсэнгүй. Тэд гадагш гарлаа. Даагаа шинэ найзаа амархан таньжээ. Түүнд “Болно” гэсэн үг тусалсан байж таарна.

Циркчний хүү охид шиг аяархан аяархан явдалтай, шингэн дуутай ажээ. Хэдий тийм боловч Даагаа “Энэ бол хүү” гэдгийг үнэрээр нь, бас зан төрх, хөдөлгөөнөөр нь мэдэж байв. Гагцхүү нэр нь тогтооход бэрх аж.

-Танилцъя! Намайг Жимбиймомолом гэдэг!

-Зүгээр л Жимбий гэж хэл!

-Жимбий!

Даагаа сурсан зангаар баруун хөлөө өргөн өгөв. Жимбийн гар зөөлхөн байлаа.

Даагаагийн хувьд энэ өдрийн тоглоом ер бусын сонин болжээ. Урьдын адил түүнийг хэн ч ийш тийшээ хөтөлж гүйсэнгүй. Мод шидээд эрж олуулах юм уу, хойд хоёр хөл дээр нь суулгах гэж зүдрээсэнгүй. Харин оронд нь шинэ танил, урт саваа мод олж ирээд Жаалхүү Үзмээ хоёрт бариулан “Харай, харай” гэж шаардав. Даагаад энэ үг цоо шинэ үг байлаа.

-Харай!

Жимбий саваан дээгүүр өөрөө харайж үзүүлэв. Дахиад хэд хэд харайжээ. Бас том алаг бөмбөг авчраад өөрөө дөрвөн хөллөж, түүнээ толгойгоор түрэн гүйв. Даагаа чимээгүй харж, хандсан зүгт нь толгойгоо гилжийлгэн, ямар хачин юм бэ гэсэн янзтай зогсоно.

Хэд хоногийн хойно бүр ч сонин юмтай учрав. Юу хэмээвээс Жаалхүү, Үзмээ, Жимбиймолон гурав Даагааг цирк үзүүлэхээр авч явжээ. Явахын өмнө зөвлөсөн нь:

-Циркэд гаднаас нохой оруулж болохгүй. Яахав?

-Хоолны том цүнхэнд хийгээд орьё! Гэж Жаалхүү Үзмээ хоёр санал гаргав.

-Аавд хэлээд араар нь орьё гэж Жимбиймолон хэлэв. Чингээд эцэст нь тэд Даагааг хоолны цүнхэнд хийгээд авч орох аргыг сонгожээ.

-Даагаа хэвт! Хөдөлж болохгүй! Хэвт!

Нохойгоо том хар цүнхэнд хийгээд Жаалхүү Жимбиймолон хоёр дамжилж, Үзмээ дагаж явлаа. Даагаа чимээгүй. Билет шалгагч дэндүү том сав дамжилсан хоёр жаалыг цаанаа айхавтар сэжиглэсэн царайтай харж байсан боловч шалгаж үзсэнгүй.

-Хэвт! Чимээгүй!

Гэрэл унтрав. Хүүхдүүд Даагааг үүргэвч цүнхнээсээ гаргалаа. Тэгтэл юу болсон гэж бодно. Даагаа цүнхнээс толгойгоо цухуйлмагц, хурц гэрэл туссан дугуй тайзны голд салбаганан гүйж яваа хачин эрээн ноорхой хувцастай алиалагчийг хараад гэнэт хуцжээ. Гайхалтай нь хүмүүс үүнийг ер анзаарсангүй. Циркид ер бусын сонин, гэнэтийн үзэгдэл байхыг алийг хэлж барах вэ. Хүмүүс алиалагчийн зүг анхааран, үе үе нирхийтэл инээлдэнэ. Хүүхдүүдийн дэргэд суусан хүмүүс ч гэсэн болж буй үйл явдалтай ямарваа учир холбогдолтой, тэр ч бүү хэл алиалагчийн туслах, сургуультай нохой сууж, хуцаж байна хэмээн бодсон янзтай харж байв.

Даагаа алиалагчийг том дэлбэгэр малгай, хиймэл урт хамраа хол үсэргэн, элгээрээ харуулдан унахад дахиад чанга гэгчийн боргов. Хүмүүс хөхрөлдөнө. Алиалагчийн унах, нохой боргох хоёр үзэгчдэд инээдэмтэй санагджээ. Харин ойролцоо хаалган дээр зогсож байсан үйлчлэгч эмэгтэйчүүд.

- Хаана, юун нохой хуцав! гэсэн байртай ийш тийш нэгжин харна. Үзмээ:

- Явъя! Гаръя! гэж Жаалхүүгийн ханцуйнаас татав. Жимбиймоллом:

- Хүлээж бай! Одоо удахгүй сургуультай амьтад тоглоно хэмээн шивнээд Үзмээг нударна.

- Даагаа хэвт! Чимээгүй! гэж нохойныхоо амыг барих шахам халаглана. Энэ зуур ашгүй гайхал алиалагч алга боллоо.

Уянгалаг сайхан хөгжим эгшиглэж, уран нугарагч бүсгүйчүүл гарч ирэв. Үзүүгчид нижигнэтэл алга ташина. Даагаа ийм их чимээ, ийм сонин юмыг ер сонссон, үзсэн удаагүй. Осолдохгүй, хоёр хөлтэй хүн баймаар атал жигтэй хачин хөдөлцгөөнө. Учрыг нь олох аргагүй орооцолдсон бөөрөнхий юм болж орхино. Хөл нь хаана, гар нь хаана байгааг таних аргагүй. Эргэлзэх хэрэггүй. Энэ бол үнэхээр хүн байлаа. Хүн ийм хачин гайхамшигт увдистайг Даагаа үзлээ. Тэр яагаад ч юм хуцсангүй. Харин хүмүүсийг шаагитал алга ташихад цочин өндөсхийв.

- Хэвт!

- Явъя! Одоохон гаръя!

Үзмээ дахиад л шаардана. Үнэхээр айж байгаа нь илт нүд нь бүлтэгнэнэ.

- Одоохон нохой гарна. Хүлээж бай!

Даагаа "Нохой" гэсэн үгийг сонсоод Жимбий үрүү гайхан харжээ. Тэр энэ үгийг хэчнээн ч хазгай хэлсэн маш сайн мэддэг юм. Хүүхэд гэдэг нь жижигхэн хүнийг нэрлэдэг үг бөгөөд тус бүрдээ нэртэй байдаг шиг нохой гэдэг бас л бүх нохойны нэр, мөн л тус тусдаа оноосон нэртэй байдаг гэж мэддэг. Жишээ нь Даагаа нохдын нэлээд хэдэн нэр тогтоожээ. Хойлог, Банхар,



Бүргэд, Барс... Бүгдээс дургүй нь Халтар. Манеж хэмээх голын дугуй талбайд цаад талын хаалганаас (Даагаагийн анх харснаар) улаан эрээн даашинзтай, үсэндээ улаан тууз зангидсан жаахан охин гүйж ирэв. Охин өрөөсөн гартаа бяцхан сагс барьжээ. Хүмүүс хөхрөлдөнө. Жаалхүү, Үзмээ, Жимбиймомом гурав ч баясан хөгжилдөнө. Гагцхүү Даагаа л гайхахгүй байгаа бололтой. Хэрэв эрээн даашинзтыг хүүхэд бус нохой гэж таньсан бол эрхгүй гайхах байсан биз.

- Нохой! Нохой шүү дээ! Жимбиймомомыг ийнхүү хэлээд манеж рүү заан өндөлзөхөд Даагаа "Нээрээ юу?" гэсэн шиг амаа ангайн, чихээ сортойлгон харав. Тэгээд яагаад ч юм, өцөс өцөс хийн хуцлаа. Олон нохой гарч ирэв.

- Хэвт! Чимээгүй! Улаан эрээн даашинзтай нохой сагсаа тавиад сургагч эзнийхээ заавраар урт саваан дээгүүр дүүлэн харайж байна. Даагаа тэр нэг өдрийн явдлыг санав. Жимбий найз нь түүнийг яг л ийм саваан дээгүүр харайлгах гэж байсан шүү дээ. Сургуультай ноход хүний хийдэг бүх хөдөлгөөнийг хийж байлаа. Энэ сацуу "Циркэд нохойтой хүүхдүүд орж ирсэн байна" гэсэн яриа гарчээ. Удсан ч үгүй нохойтой жаалуудыг үйлчлэгчид суудал дээр нь барьж авав.

- Та нар юун хүүхдүүд вэ? Яагаад гаднаас нохой авч оров?

Хэн ч хариу хэлж чадсангүй. Тэгтэл үйлчлэгч эмэгтэй Жимбиймомом уруу оноон харж байснаа:

- За байз, чи чинь хэний хүүхэд билээ? гэж асуулаа.

- Би юу? Сэргэлэн гуайн хүүхэд...

- Тийм байхаа. Үзсэн жаал шиг байсан юм явъя. Аав дээр чинь аваачиж өгнө дөө хө!

Бүтэлгүй юм болж байгааг Даагаа зөнгөөрөө мэдэж байлаа. Тэр үргэлж годойлгож явдаг сүүлээ буулгаад гаслан гийнасаар ажээ.



## ЗУРГУУЛАА

Сар, өдөр өнгөрсөөр байтал Даагаагийн амьдралд харамсалтай гэмээр нэг гунигтай явдал тохиолдов. Үзмээ үзэгдэхээ байжээ. Түүний урьхан дуу, зөөлхөн гарыг үнэхээр үгүйлж байлаа. Үзмээ охин эмнэлэгт түр хэвтсэн байв. Жаалхүү Даагаагийнхаа ямар нэгийг үгүйлэн халаглах мэт гийнахыг сонсох бүр Үзмээг дурсан санаж байна даа гэж мэдээд түүнд аль болохоор ярьж ойлгуулах гэнэ. Хэдий тэр ухаантай, сэргэлэн нохой гэгдэх боловч “Үзмээ” гэснээс өөрийг үл мэднэ. “Эмнэлэг”, “Өвчин” гэсэн үгийг хэчнээн хэлэвч ухаарахгүй, соотон чихээ өргөөд толгойгоо гилжийлгэн өөдөөс нь гөлрөн ширтэнэ.

Аливаа үгийг маш олон хэлүүлж байж тогтоодгоороо нохой хүүхдээс ялгаатай, үүгээрээ тун ч өрөвдөлтэй ажээ. Даагаа нэг өдөр алга болов. Жаалхүү сүүнд явахдаа түүнийг жаахан зугаалбал ч зугаалаг гэж бодоод сул тавьсан байлаа. Дэлгүүрээс ирээд хайвал ойр хавьд байсангүй. Чухамдаа Даагаа тэр өдөр Үзмээг л эрж явжээ. Нэг хүүгийн мэдээлснээр Даагаа Үзмээгийн байрны үүдийг самардан цоройж байсан гэх бөгөөд өөр нэг жаалын үзсэнээр бол тэр хэсэг охид уруу давхин одсон, охид учиргүй айж зугтаасан бололтой.

Тэгээд... тэгээд хөөрхий нохой үл бүтэх амьтны гарт оржээ. Энэ тухай өгүүлэх нь:

Даагаад Үзмээгийн үнэр хаанаас ч үнэртэхгүй байлаа. Үргэлж шахам үүрч явдаг ширэн цүнхээр нь хайрт найзаа танина гэдэгт тэр бат итгэжээ. Сууцныхаа нэг байрны хаалганы завсраас тэрхүү цүнхтэй төстэй үнэрийг унхиадан байж олсон боловч үүдээ нээж өгсөнгүй. Одоо хайчих вэ? Харих уу?

Даагаа Үзмээгийн явдаг зүг чигийг мэдэх юм. Энэ бол эцсийн горьдлого бөгөөд байрнаас сургууль хүрдэг найдваргүй шахам зам билээ. Чингээд сургууль тийш галзуурсан юм шиг гүйжээ. Үзмээ хаана ч алга. Буцав. Тийн гэрийн зүг явж байтал гэнэт

сүр сар хийх чимээ гарч, хэн нэгний ширүүн гар түүний шилэн хүзүүнээс шүүрэн аваад, хөлийг нь хөндийрүүлэв. Даагаа хэн болохыг танилаа. Нөгөө Халтар гэдэг хүү ажээ.

Ингэж бяцхан нохой өөр эзний эзэмшилд очиж билээ. Халтар бол Цагаан давааны гэр хороололд байдаг, аминдаа үнээ, ямаатай айлын хүүхэд юм. Шинэ эзэн нь Даагааг хашаандаа аваачсан даруй, хуучин хүзүүвч, уяаг нь тайлж аваад оронд нь бүдүүн төмөр утсаар гинжилж хийсэн жигтэйхэн хүнд уяа зүүж, жижигхэн пин шиг юманд хийжээ. Энэ пинд урьд өмнө ямар нэг нохой байсан нь илт бөгөөд ой гутам эвгүй шинхэг, шороонд хутгалдсан ясны хуршмал хуучин үнэр ханхалж байлаа.

Даагаа хүзүүнээсээ зүүсэн төмөр уяанаас татаж, арагшаа цахалж үзсэнд гинжний нөгөө үзүүр газраас цухуйсан ямар нэг бэх бат юманд бэхлэгдсэн байх ажээ. Одоо хаашаа ч гарч чадахгүй болсноо мэдлээ. Дэмий л гаслан гийнана.

Тэр шөнө Даагаа дугхийсэнгүй. Нөгөө шинхэг, хуршмал үнэр сэнгэнэнэ. Бас л үл таних хачин үнэр үнэртэнэ. Тэр бол үхрийн үнэр, бас ямааны үнэр байжээ. Өглөө болоход Даагаа юу гээчийн газар, ямар амьтдын дунд ирснээ хараад цочлоо. Эхлээд толгой дээрээ хоёр махир юмтай, цангинасан дуутай саарал амьтдыг олж үзээд айх шиг болов. Тэдгээрийг өөртөө хал балгүй ямаа гэгч болохыг Даагаа хэрхэн таних вэ. Удалгүй бас айж үхмээр том хүрэн амьтныг харуут хирдхийв. Урьд нэг удаа үхэр үзсэн боловч эргэлдсэн алаг нүд, хамрынхаа нүхэнд ордог урт ягаан хэл, том дарвагар ам, жигтэй дэнхэр толгойг нь тийм ойрхноос харсан удаагүй.

Энэ бүхнээс болоод Даагаа нөгөө өмхий оромжиндоо арга буюу шурган оржээ. Өлсөж цангаж байгаа гэдэг нь жигтэйхэн. Өчигдөр өдрөөс хойш юу ч амссангүй. Өлсгөлөн болохоор нойр нь хүрсэнгүй. Даагаа болсон явдал бүхнийг, хуучин эзэн тоглож байсан найз нараа, бүгдийг нэхэн санах гээд чадсангүй. Тэр хүн гэгч амьтныг анх бээрээд үхэх гэж байхад нь олж авчирсан Жаалхүү гэдэг ачтай эзэн, Үзмээ, Болдоо, Жимбий найз нар шиг

ачтай сайн хүмүүс байдаг, хүний амьдрал гэгч өвлийн хүйтэн, хаврын жаврыг өнгөрөөсөн дулаан байр, өнгө өнгийн гэрэл цацарсан циркийн танхим шиг л үзэсгэлэнтэй сайхан орчлон байдаг хэмээн ухаарч мэдэрч явсан байж. Чингэтэл шинэ эзний хашаанд хоёр хоносны дараа өөр болжээ. Хамгийн их айж байгаа хачин толгойтой цэнхэр амьтан, том нүдтэй хүрэн амьтан хоёр нь ердөө ч аюултай биш, харин үзэхүл энэ айлын хүмүүс, түүн дотроос чирч гулдарч авчирсан Халтар хэмээх хүү л хамгийн айдастай ажээ.

Хоёр хоноход эзэн нь түүнд нэг ширхэг түүхий булуу, аяга хэртэй угаадас өгсөн байлаа. Даагаа хэзээ ч түүхий мах идэж үзээгүй юм. Гэвч ам хүрэх л хэрэгтэй болов.

Ийм явдал болж байхад Жаалхүү найз нартайгаа хамтран нохойгоо эрсээр байжээ. Даагааг алга болсныг дуулаад Үзмээ шиг харууссан хүүхэд үгүй. Тэр эмнэлгээс гарч ирсэн даруй хөвгүүдтэй хамт эрэлд гарав.

- Даагааг ямар нэг хүн хулгайлсан байх.

- Үхсэн ч байж болно.

- Үгүй бол ээжийгээ олоод, дагаад явчихсан ч юм билүү дээ.

Хүүхдүүд янз янзаар тааварлан ярьж, байж магадгүй гэсэн газраар хайлаа. Тэд голдуу хотын захын айлуудын хашаа, гудамжаар яваад олсонгүй. Сураг ч гаргаж чадсангүй.

- Одоо хаагуур эрэх вэ? Хулгай хийсэн бол түүнийг хэн авсан байж болох вэ?

Хүүхдүүд бие биенээсээ ийнхүү асуугаад хэд хэдэн нэр хэлэв.

- Ганбаа хулгайлсан байж мэднэ. Эртээд тэр чинь байрныхаа доод хонгилд таван жижигхэн гөлөг хорьчихоод байсан гэнэлээ. Тэгээд байрны даргадаа баригдсан дуулдсан гэж Жимбиймоллом яриw. Болдбаатар Маахуур хавиар явж байгаад бас нэг аймаар мэдээ сонсч иржээ.

- Зүүн сургуулийн Домбон, Шомбон нарын хэдэн жаал нэг гөлгийг дайсан болгож, утасны модноос дүүжилжээ гэw.

- Арай Даагааг маань тэд дүүжилчхээгүй байгаа даа! гэтэл дуугүй сонсч зогссон Үзмээ эхэр татан учиргүй мэгшин уйлав.

Үхлээс энэ охин айдаг болжээ. Түүний нүдэнд Даагаа нь хаа нэгтээ гуу жалганд үхчихсэн хэвтээ юмуу, эс бөгөөс найз нартаа учиргүй их гомдчихсон, сүүлээ годойлгоод гаслан гүйж яваагаар үргэлж харагддаг, шөнө зүүдлэгддэг болжээ.

Харамсалтай нь тэдний хэн нь ч гэсэн Халтарын талаар сэжиг санахгүй байлаа. Халтар ойрд үзэгдсэнгүй. Өөр сургуулийнх болохоор яаж дандаа тааралдах билээ.

Даагаагийн алга болсон нь Жаалхүүгийн аав, ээжид ч харамсалтай байжээ. Тэд хүүгээ эрэл хатал болж байгаад санаа зовохын зэрэгцээ, тэр нялх амьтныг "Яаж зовж буй бол" гэж бодно. Нэг өглөө Жаалхүүгийн аав:

- Та нарт атаархдаг хүүхэд байсан уу? хэмээн гэнэт асуув.

Энэ сацуу Жаалхүү Халтарын хэлсэн үгийг гэнэт саналаа. Гэвч аавдаа нэрийг нь дурдсангүй. Харин найз Жимбиймоллом, Болдбаатар нартаа Халтарыг сэжиглэж байгаа тухайгаа ярьжээ.

Ингээд тэд эрлийнхээ чигийг өөрчлөв. Юун түрүүнд Халтарын хашаа, гэр хаана байдгийг мэдэхээр тогтлоо.

Гуравдугаар улирлын амралтын үе, Болдбаатар, Жимбиймоллом хоёр Халтарын хашааг мэдэх нэг хүүтэй Цагаан давааны хороолол уруу явав. Хүүгийн нэрийг Сүхболд гэдэг ажээ. Сүхболд биеэр том учир Халтараас огт айдаггүй бололтой. Тэр замдаа:

- Тэднийх үнээтэй, ямаатай. Ноднин нохойгоо алуулчихлаа гэж ярьж байсан. Ер нь Халтар авсан байж мэднэ.

Тэд олон эгнээ хашааны дундуур орж, зүүн захын том хүрэн хаалганы үүдэнд хүрч ирэв. Эхлээд хашааны сургаагны завсраар шагайлаа. Дотор гүйж яваа юм харагдсангүй.

- Яахав, орох уу?

- Тэгье.

Хаалгыг цүү, цуургаар нь харшуулж, зориг муутайхан

цохисонд гэрээс нэг эмгэн гарч ирэв. Тэр хаалга тайлж өгөхдөө асуув.

- Та нар юун хүүхэд вэ?

- Эмээ! Бид Халтарыг... Үгүй ээ, Даагааг...

- Юу? Юун Халтар, юун Даагаа...

- Нохойгоо эрж явна.

- Эцэг элэнцэгийн чинь нохой. Байтлаасаа муу бандийг минь нохой мохой гэх нь үү? Яасан цадиггүй багачуул гээчिव.

Эмээ халгаах янзгүй байснаа ширвэж хараад эцэст нь:

- Явцгаа! Халтар үхрээ бэлчээрт аваад явчихсан. Өглөө л гарсан гэж хэлжээ.

- Халтар, нохойгоо аваад явсан уу? гэж Сүхболд амжиж асуув.

- Хөтлөөд л явах нь билээ. Яах гэв! Гэж эмээ ууртай хэлүүт хаалгаа түгжиж орхилоо.

- За мөн дөө. Халтар авсан байна. Түүнд ямар нохой байх вэ.

- Явцгаая! Энүүхэн хойд энгэрт л байгаа байх.

Хүүхдүүд ингээд армаг тармаг цастай бяцхан гүвээ өөд өгсөв. Гүвээн дээр гартал халтар хэдэн үнээгээ туусаар эгц өмнөөс нь гарч ирлээ. Тэр Даагааг хөтөлжээ.

- Мөн байна. Миний Даагаа. Оллоо! чамайгаа. Ээ гялай, гялай.

Халтар яаж ч чадсангүй. Гурван хүүхдийн өөдөөс хээр хөдөө хэрхэх ч билээ. Тэр Сүхболдоос айдаг нь үнэн аж.

- Муу дээрэмчин! Яах гэж чи эдний нохойг хулгайлж авав! Өг! одоо.

Халтарын ам өмгөнөвч үг эс гарна. Даагаа эзнээ хараад энгэр заам уруу нь өрөвдөлтэйгөө цовхчин гасалж байлаа. Хөөрхий нохой турж, өнгө алдаад муухай болсон гэдэг жигтэйхэн. Хүзүүний нь үс хүнд төмөр гинжинд зулгарч, жижигхэн сайран хамрынхаа дээр бяцхан сорвитой болжээ. Сар шахмын хугацаанд мундахгүй зовлон амссан бололтой.

Хүүхдүүд сайн найзын ачаар Даагаагаа ийнхүү олж аваад





ээлжлэн тэвэрсээр байрандаа хүрч иржээ. Энэ бол тэдний хувьд том ялалт байлаа. Гэвч ялалт бүхэн эцсийнх байдаггүй. тэмцэл үргэлжлэх ч бий. Үргэлжилбэл юугаар төгсдөг бол? Халтар яахаас ч буцахгүй, хөмхий зуун занасаар хоцорчээ.

## ДОЛУУЛАА

-Халтар чамайг яаж зодсон бэ? Хүзүүний чинь үс юунд халцрав. Хамрын чинь дээрх сорви ямар учиртай юм бэ? Хадаасаар хатгасан уу? Үзмээ ингэж асуужээ.

Даагаа дэмий л баярлаж хөөрсөн амьтан байв.Өөрөөр ч хэрхэх билээ. Хайртай найзууд дээрээ ирсэн нь түүнд бөөн аз байсан болохоор аргагүй. Хэрэв тэр хүний хэл мэддэг байсан бол мундахгүй зовлон тоочихсон биз. Юун түрүүн Үзмээг санаснаа ярина. Тэгээд "Чи хаачсан юм бэ? Дахиад алга болохгүй биз дээ!" гэж асууна. Дараа нь зовлонгоо тоочиж эхэлнэ.

-Халтар намайг хүзүүн дээрээс минь шүүрч аваад гэр лүүгээ гүйсэн. Хоёр удаа хоолойноос өвдтөл базсан. Би түүний гарыг хазаж тавиулах гээд чадаагүй. Замдаа Үзмээ, Жаалхүү бас Болдоо, Жимбий та нарыг дайралдах болов уу гэж их харсан. Хэн чинь ч харагдаагүй. Танил үнэр ер үнэртээгүй. За, тэгээд Халтар намайг гэртээ аваачаад муухай өмхий пинд хийчихсэн. Аймаар хүнд төмрөөр уясан учир би яаж ч чадаагүй. Надад тэднийх дандаа ув улаан мах өгч байсан. Анхандаа ой гутаад идэж чаддаггүй байснаа хожим нь сурсан. Хэдэн шөнө нойр хүрээгүй. Гэвч унтдаг болсон. Нэг удаа унтаж байхдаа та нарыг зүүдэлсэн. Жаалхүү Үзмээ та хоёртой хамт байх юм. Үзмээ миний нурууг илж байх юм. Ингэж зүүдэлсэн. Тэгтэл миний нурууг нэг ямаа үнэрлэж байжээ. Ямаа аймаар боловч гэмгүй амьтан. Үхэр ч гэсэн ялгаагүй. Нүд нь даанч том доо. Толгой

дээрээ хоёр урт махир юмтай. Ямааныхаас хамаагүй бүдүүн. Хэрэв надад тийм том, үзүүртэй махир юм байсан бол Халтарыг би айлгаж чадах байлаа. Түүгээрээ өвдтөл нь хатгаад зугтаах байв. Нохойд яагаад тийм юм байдаггүй юм бэ? Нохой яасан азгүй амьтан бэ?

Халтар надад хачин нэр өгсөн. “Мухтар” гэж дууддаг байлаа. Юу гэсэн үг юм бэ? Би энэ нэрэнд дургүй хүрдэг байв. Дуудахад нь очдоггүй байсан. Тэгээд тэр үү, Халтар миний хоншоор луу төмөр саваагаар шавхуурдсан юм. Сорви нь энэ байна. Би хамрынхаа дээр байгаа сорвийг хараад уйлсан. Та нар нохой уйлдаггүй гэж бодно уу? Өлсөхөөрөө, хүнд зодуулахаараа, хайртай эзнээ санахаараа уйлдаг юм шүү. Дандаа л уйлдаг байлаа. Нээрээ шүү! Та нар намайг яагаад очиж аваагүй юм бэ? Санаагүй юм уу? Уйлдаггүй байсан юм уу?

Халтар намайг нөгөө хүнд төмөр уяанаас хөтлөөд үхэртэй хамт уул руу явдаг боллоо. Хөдөө очоод надтай эрхлэх гэнэ. Би тоглох дургүй байсан. Тоохгүй болохоор тэр хоёр хөлөө жийж суугаад өврөөсөө дугуй савтай, муухай үнэртэй нунтаг юм гаргана. Түүнээ цаасанд ороогоод амандаа зууна. Дараа нь нарийн модыг өөр нэг юманд хавирч гал гаргаад зуусан юмандаа хүргэнэ. Хүргэмэгц Халтарын ам, хамраар утаа савсана. Нэг удаа Халтар амаа миний хамар луу шахан ойртуулж, ой гутам үнэртэй утаагаа үлээсэн. Би хахан цацаж, дахиад л уйлсан. Харин Халтар инээж байлаа. Удалгүй бас зуусан зүйлээ авч нэг үзүүрээр нь яг сайран хамар дээр хүргэсэнд би өөрийн эрхгүй цовхрон боссон. Хэчнээн их өвдөж, хожим хойно болтол хорсдог байсан гэж санана. Халтарын өвөрт байдаг дугуй савтай зүйлийг юу гэдэг юм бэ? Яагаад та нарт байдаггүй юм бэ?

Та нарыг очиж аваагүй бол би үхэх байсан байх аа. Би үхэх дургүй. Ингээд л та нартай хамт, тоглож байх дуртай. Намайг Халтарт дахиад битгий өгөөрэй!... Битгий өгөөрэй...

Даагаа лав ингэж ярих байсан биз ээ! Ингэж яриагүй ч гэлээ найз нар нь түүнийг ийнхүү өгүүлж байна гэж бодож байжээ.



Яагаад ч юм, хүүхдүүдэд Даагаа нь цаанаа л нэг бодлогоширсон, ямарваа юмнаас айж цочсон буюу чимээ чагнан болгоомжилж буй мэт санагддаг байв. Ганцаараа гадуур тэнэх дургүй. Тэр үнэндээ айж байлаа. Найз нартайгаа байлаа ч гэсэн ийш, тийш сэжигтэй харж, болгоомжтой гүйнэ.

- Даагаа ухаантай нохой болохоор хаширчээ.

- Халтараас л айгаад байгаа бололтой гэж хүүхдүүд таамаглана.

Энэ нь нэг талаар үнэн боловч нөгөө талаар Даагаад хорсол бага, багаар бүрэлдэн бий болсоор байжээ. Тэр хорсол өдөр, хоног өнгөрөх тутам өссөөр байсныг хүүхдүүд хэрхэн мэдэх билээ. Адгуусан амьтад, түүн дотроос нохойд өөртөө сайн мууг ялган мэдрэх, сайнд тус үзүүлж, мууд дайсагнаж чадах төрөлхийн ая зөн байдаг юм. Үүнийг хүүхдүүд төдийгүй, томчууд хэдэн сарын дараа үзжээ.

Өгүүлэх нь: Хойтон жилийнх нь зун хотын айлууд зусландаа гарав. Жаалхүү Болдбаатар нарын аав нэг албан газрынх тул “Чингэлтэйн богино” хэмээх амнаа цуг зусдаг билээ. Дэлгэр сайхан цагт уул ус жигдэрсэн эрүүл саруул газар амьдарна гэгч хэн хүнд баяр, Даагаагийн хувьд юутай сонин байсныг өгүүлэх юун.

Хүүхдүүдтэй усанд хамт явах, түлээчин жаалуудтай ойн зөргөөр одох буюу зуны байшингийн үүдний саравчинд шөнө гадаа унтах түүнд өгүүлж баршгүй жаргал байжээ. Одод анивчин гялалзах, цахилгаан цахиж, азарган бороо гэнэт шаагин асгарах, урийн ус улаан хоормог болж уруу газар луу үерлэн буух ч сонин сайхан.

Гэвч бүхнээс нэг зүйл Даагаад сонин байлаа. Зусланд ямаа, мал олон авч Халтарын ямаа, үхэр алга. Тэр сайтар зүсэлж авсан учир хаана ч явсан таних байжээ. Үүнчлэн хүүхэд үй түм боловч Халтар бас үгүй. Үхэртэй газар Халтар, Халтар байгаа газар үхэр байх ёстой нь худал аж. Даагаа анхандаа эргэлзэж байлаа. Нэг өдөр Даагаа үхэр, ямаатай айлуудын хавиар баахан

яваад түүнийг олсонгүй. Халтарын үнэрийг авах гэж л явсан хэрэг шүү дээ. Урьдыг бодоход том нохой болсон болохоор ч тэр үү айхгүй байв.

Чингээд намар боллоо. Жаалхүүгийн ээж аав, эрүүл агаарт хэд хоновол хоног хэмээн Үзмээ охиныг авчирчээ. Энэ удаа Даагаа Үзмээг бус, Үзмээ л Даагаагаа илүү их санасан бололтой байв.

-Цагаан сүүлт годгорхон маань мөн ч том болжээ. Би чамайг их санасан шүү гэж Үзмээ үглэнэ.

Ийнхүү ярихыг хүмүүс сонсоод шүүрс алдана. Хэдий тийм боловч тэд Үзмээ охины үл сонсдох яриаг анзаарч мэдэхгүй. Тэр Даагаадаа "Би чинь ээж, аавгүй хүүхэд шүү дээ". Чи бид хоёр яг адилхан. Гэвч хоёулаа жаргалтай байна. Жаалхүүгийн аав ээж шиг ухаантай хүнийг олох нь хэцүү. Аав нь худаг усны мэргэжилтэн. Хаа явсан газраа ус гаргаж явдаг юм. Дандаа хөдөө явна. Одоо ч алга байна. Энэ хүн л чамд улаан хүзүүвч хийж, тусгай номер олж өгсөн шүү дээ. Жаалхүүгийн ээж гутал хийдэг юм. Харж байна уу? Яг миний үүн шиг гутал хийнэ. Надад хэчнээн хайртай гэж бодно. Гутлыг минь энэ хүн л тахалж, оёж өгнө. Ийм л хүмүүс чамайг гэртээ байлгаж байна шүү дээ. Хүнд хайртай хүн нохойд ч бас хайртай байдаг юм уу даа.

Даагаа, чи сонс! Хоёулаа бушуухан том больё. Үхэж ер болохгүй, за юу" гэж хэлдэг байжээ.

Жаалхүү, Болдбаатар, Үзмээ нар айлын хэдэн хүүхэдтэй хамт ой уруу жирх хөөн одно. Төдөлгүй эргэж ирнэ. Даагаа тэднийг дагаж, нэг үе түрүүлэн, нэг үе зөргөөс гарч, ой уруу жирх хөөн одно. Төдөлгүй эргэж ирнэ.

Даагаа бусад нохдын адил айхавтар үнэрч билээ. Түүний энэ гайхам чанарыг мэддэг хүн бол зуслангийн манаач Лувсан өвөө юм. Өөртөө сайн байгааг Даагаа мэдээд түүний үгэнд ордог болжээ. Өвөөгийн үнэрийг сайтар тогтоож авчээ.

Даагаа гэнэт зогсож, чихээ сортолзуулав. Хол саахалтын хэртэй газар Лувсан өвөө ирж явааг мэджээ. Хүүхдүүдийг

амрахаар суух хооронд Даагаа найз өвөөгөө тосохоор буцаж гүйв. Лувсан гуай:

-Хүүхдүүд минь, намар зуслангаас буухдаа Даагаагаа надад үлдээсэн нь дээр биз. Өвөө чинь үүнийг анд сургая гэж хэлдэг болжээ.

Жаалхүү “за” гэж зүрхлэхгүй байлаа. Тэр “Юу ч гэсэн энэ өвөлдөө хотод байлгая. Ирэх намар л өгч болох юм” хэмээн бодож байсан ажээ.

Өвөө зөрөг замаар гарч ирэв. Ийнхүү тэд манаачтай цуг ойн тагт өөд өгслөө. Лувсан гуай ядарч буй бололтой, замаас олсон хуурай мөчрөө тулан үе үе зогсосхийнэ.

- Та хаачиж яваа юм бэ? Бид самар, жимсний мод, бут гэмтээхгүй. Унасан самар аваад л буцна.

- Та нар ч яахав. Саяхан хотоос гарсан бололтой хоёр жаал ийшээ өгссөн. Тэдний юу хийж байгааг мэдэлгүй горьгүй.

Тэд дээшээ улам бүр өгссөөр байлаа. Ойд чимээ аниргүй. Балар их ойд үй түмэн шувууд, араатан, гөрөөс хаашаа алга болоов гэж гайхмаар нам гүм ажээ. Чингэтэл Даагаа ямар нэг анир, үнэр авсан бололтой, уулын тагт өөд өлийн унхиадна. Лувсан өвөө:

- Хүүхдүүд ээ! Чимээгүй явцгаагаарай! Дээшээ жаахан өгсье! Нөгөө хоёр жаал холгүй байгаа бололтой гэж хэлэв.

Даагаа байж ядаж буй янзтай эргэцэн, чихээ сортолзуулна. Хүүхдүүд ч ажиг сэжиг авчээ.

- Чимээгүй!

- Чишш! Зөөл-хөн я-ваа-рай!

Холгүй мөир хугалах сонсогдлоо. Лувсан өвөө, дараа нь Үзмээ зогсов. Бүгд амьсгаа даран зогсоцгоолоо. Дахиад тас, няс хийх чимээ... Даагаа улам ч шуналтайяа үнэрлэнэ, толгойгоо гилжийлгэж, чимээ чагнах мэт ажээ. Тэр бөв бөөрөнхий хоргол нүдээрээ “Би явья. Та нарт тусалъя” гэж хэн хүнд шулуухан хэлж байлаа. Үүнийг манаач өвөө л ойлгов. Өвөө Даагааг хзүүдэн, нурууг нь илэх мэт болсноо хондлой дээр нь цохих

аятай зөөлхөн түлхжээ. Энэ сацуу Даагаа замын хажуугийн өтгөн модон дундуур янзага шиг үсчин одлоо.

- Алив, хүүхдүүд минь яваарай!

Өвөөгийн тушаалаар бүгд Даагаагийн хойноос гүйлдэв.

Хожимджээ. Даагаа хаачсаныг бүү мэд!

Том хушны ёроолд шуудай дүүрэн самар хэвтэнэ. Түүнийг тойроод хугарсан мөчрүүд ногоорон байна. Ой сүйтгэгчид нэгтээ амжин зугтааж, Даагаа тэднийг хөөснөөс зайлахгүй.

- Хэн байдаг билээ! Даагааг ийм ажилд хэн ч сургаагүй шүү дээ.

Хүмүүс хаашаа зайлав? Даагаа яагаад тэднийг хөөв? Ийн бодоод бие бие рүүгээ гайхан ширтэж зогстол гэнэт Даагаагийн гаслан гангинах сонсогдлоо.

Хүүхдүүд үргэсэн шувууд шиг зэрэг дэрхийн дэгдэв. Манаач өвөө ч тулж явсан модоо хаяад ухасхийв.

Самрын мод сүйтгэгчид холдож чадсангүй. Тэд баригджээ. Үзвэл Даагаа нэг хүүг ноцон барьсан байлаа. Гэмтэн жаал зугтааж явахдаа бөөн гишүүн дунд таварцаглан унасан бололтой. Тэр гар хөлөө сарвагануулан тийчилж, Даагаа хазах газраа олж ядсан байртай үсчин хуцна. Нөгөө жаал нь хүмүүс ирэхийн бараанаар нохойг цохих гэж далайсан модоо хаяад ухрав.

- Даагаа! Боль!

- Боль! Даагаа!

- Аа, чи юу?

- Халтар чи ингэж явдаг вий!

Халтар хөлс, нулимсаа арчсаар бослоо. Ийм явдал болжээ. Лувсан өвөө сайхь хоёр жаалыг хөтлөөд, Жаалхүү Үзмээ хоёр Даагаагаа хөтлөөд буцав.

## НАЙМУУЛИАА

Хөгжилтэй сайхан өдрүүд өнгөрсөөр удалгүй өвөл болж, төдөлгүй бас хаврын сар гарлаа. Даагаа сайхан том нохой болжээ. Ямарваа амьтан өсч томрох нэг хэрэг, өсөхийн хэрээр ухаан, зориг нэмэгдэнэ гэгч өөр зүйл. Даагаа хүний ачийг, тэр тусмаа сайн хүүхдүүдийн тусыг хэзээ ч мартахааргүй болсон байв. Түүнийг дөнгөж нүдээ нээгээд, өлбөрч осгож үхэх дөхөж байхад нь хэн тус болсон бэ? Өрөвч сэтгэлтэй хүүхэд. Бусдад булаалгаад, зодуулж шаналж явахад нь хэн аварсан бэ? Бас л сайн хүүхдүүд. Хүний сэтгэлийг ойлгоход нь хэн тусалсан бэ? Хүний амьдрал. Бага ч гэсэн гавьяатай үйлс бүтээхэд нь хэн түүнийг сургасан бэ? Мэдээж найзууд нь.

Баярлах, хайрлах, туслах, жигших, тэмцэх энэ бүхнийг Даагаа нохойноос бус, гагцхүү хүнээс л, тэдний амьдралаас л сурсан байлаа. Даагааг тусгай дэглэмд "хичээллүүлсэн" бол ертөнцийн хамгийн ухаантай нохдын адил гавьяа бүтээх байсан байж мэднэ. Гэвч ийм хувь түүнд ноогдсонгүй нь харамсалтай.

Даагааг Халтар хорложээ. Жаалхүүг хичээлдээ явсан хойгуур баривчлан авч байшингийн дээвэр дээр чирч гаргаад түлхчихжээ. Хэчнээн цахалсан боловч тэр тогтож чадсангүй ажээ. Хортон этгээд өнгөрсөн зун ойд ноцон барьсан гэж хонзон санаснаас ийнхүү мунхаг хэрэг үйлдсэн хэрэг.

Даагаагийн хамраас цус садгадан, амаар нь хүрэн хөөс сахарч байлаа. Байрны хүүхдүүд бараг бүгдээрээ цугларав. Хэн нэг нь хувингаар ус авчирч цацна. Сэхээх гэж тэр. Хоёр жаал орныхоо эрээн ноосон хөнжлийг хуулан авчирчээ. Тэд даарснаас бус өвдөж амь алдах дөхснөөс дагжин чичирч байгаа биеий нь хөнжлөөрөө хучлаа.

Часхийтэл бахирах шингэн дуу хадав. Үзмээ ирсэн байна. Жаалхүү, Болдбаатар, Жимбиймоллом нар чимээгүйхэн мэгшинэ.



Юу болсныг мэдэхээр томчууд ч цугларчээ.

- Хэн Даагааг ингэв.

Хариу үл сонстоно. Даагаа эцсийн тэнхээгээ шавхах мэт толгойгоо хэдэнтээ хөдөлгөхдөө Жаалхүү, Үзмээ болон бусад найз нараа нэг нэг оноон харав. Тэгээд “Баяртай” гэсэн шиг товчин хар нүдээ алгуур анълаа. Хүүхдүүд хайртай нохойгоо өрөвдөж уйлаад, эцэг эхчүүд хүүхдээ хайрлан дор бүрдээ л нулимс унаган зогсоно. Хэн бүхнээс илүү Үзмээ охин гингэнэтэл уйлна.

“Бичинь ээжаавгүй хүүхэд шүүдээ! Чибидхоёряг ладилхан... Хоёулаа бушуухан том больё! Үхэж ер болохгүй! За юу?”  
Даагаад энэ үгийг Үзмээ хэлж билээ.

## ТӨГСГӨЛ

Даагааг найз нар нь Маахуур толгойн хойд энгэрт оршуулсан юм. Уужим багтах нүх ухаад толгойг нь хойш харуулан тавьж, шороогоор булжээ. Толгой талд нь том хавтгай чулуу зоогоод дээр нь шохойгоор “Даагаа (1979-1981)” гэж бичсэн гэдэг. Хүүхдүүдийг буцсан хойно түүний шарил дээр найман чихэр байлаа.

Даагаа наймуулаа байсан юм. Мэдээжээр эхлээд Даагаа өөрөө, дараа нь түүний ачтай эзэн Жаалхүү, найз Үзмээ, Болдбаатар, Жимбиймоллом, Сүхболд, зуслангийн манаач Лувсан өвөө, үнэн болсон энэ үйл явдлыг эвлүүлэн бичигч миний бие билээ.

Бид Лувсан өвөөгийн үгэнд орж өнгөрсөн зун Даагаагаа тэднийд орхисон бол ийм эмгэнэлт явдал тохиолдохгүй байсан байж болох шүү! Даан ч яав!

Баяртай, цагаан сүүлт годгорхон минь!

## ГАРЧИГ

Эхлэл	3
Ганцаараа	3
Хоёулаа	8
Гурвуулаа	14
Дөрвүүлээ	21
Тавуулаа	29
Зургуулаа	37
Долуулаа	43
Наймуулаа	50
Төгсгөл	51





Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй  
«Хөдөөгийн боловсролыг дэмжих  
(READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв.  
Худалдахыг хориглоно.